ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2016 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 оны 01 дүгээр сарын 19 Улаанбаатар хот

Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол шийдвэр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2016 онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил араг хэмжээ болон Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлж, алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах, Байгууллагын соёл, алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах, Сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх гэсэн зорилтыг дэвшүүлж, дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаа.

*Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар:*

Монгол Улсын Их хурал, Засгийн газраас баталсан хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, дээд шатны байгууллага, албан тушаалтны тогтоол, шийдвэр, эрх зүйн акт тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын засгийн газрын үйл ажиллагааны эхний 100 хоногт хийх ажлын төлөвлөгөөний цагдаагийн байгууллагад холбогдох заалтыг хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хүргүүлэхийн зэрэгцээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдаанд 11 удаа оролцож, хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг нэгтгэн тухай бүр хүргүүлэн, цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэсэн ажлын мэдээллийг бэлтгэн танилцуулав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Цагдаагийн ерөнхий газрын даргатай, Цагдаагийн ерөнхий газрын даргаас албад, харьяа газар, хэлтсийн дарга нартай 2016 оны менежерийн үр дүнгийн гэрээ байгуулах, 2015, 2016 оны үр дүнгийн гэрээг дүгнүүлэхэд шаардлагтай мэдээллийг бэлтгэн хүргүүлж ажилласан бөгөөд 90.4 дүнтэй дүгнэгдэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/54, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны А/25 дугаар тушаалаар Хууль сахиулахын их сургуультай хамтарсан ажлын хэсэг байгуулан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, ЦЕГ-ын даргын энэ оны 01/103 дугаар албан бичгээр яамаар уламжлуулан нд хүргүүлж, Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг төсөлд дахин тусгаж, Тэргүүн дэд даргын 2016 оны 2/269 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хурал 2016 онд 14 удаа хуралдаж, удирдлага, зохион байгуулалтын 29, харьяа нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт болон хэсэгчилсэн шалгалт, алба хаагчдын гаргасан зөрчилд албаны шалгалт явуулсан дүнгийн тухай 62, хүний нөөцийн холбогдолтой 13 удаагийн багц нийт 104 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Энэ хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын даргын А тушаал 100 /удирдлага зохион байгуулалтын/, Б тушаал 741 /хүний нөөцийн/, тэргүүн дэд даргын Б тушаал 90, дэд даргын А тушаал 14, Б тушаал 24 тус тус батлагдан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллав.

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнийг 02 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгуулан 109 удирдах алтныг хамруулсан бөгөөд 2015 оны үр дүнгийн гэрээг дүгнэж, 2016 оны үр дүнгийн гэрээг шинэчлэн байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газраас Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар Төмөр замын газар, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Төрийн банк, Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль, Монголын сурагчдын холбоо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүйсийн тэгш эрхийн төвтэй "Хамтын ажиллагааны санамж бичиг", Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар, Монгол шуудан ХК, Зэвсэгт хүчний жанжин штабтай "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, Гааль, татварын ерөнхий газрын даргатай "Журам, маягт батлах тухай" хамтарсан тушаалыг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 659 дүгээр тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжилтийг хангах зорилгоор "Дотоод хяналт аюулгүй байдлын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө", "Цагдаагийн байгууллагын дотоод аудитын жилийн болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө", "Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын жилийн төлөвлөгөө", "Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө"-г гарган хэрэгжүүлэн ажиллаа.

Батлагдсан удирдамжийн дагуу Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс, Говь-Алтай, Дархан-Уул, Хэнтий, Сүхбаатар, Ховд аймаг дахь цагдаагийн газар, Замын цагдаагийн алба, харьяа нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, Интерполын үндэсний төв товчооны ажлын алба, Холбооны хэлтэс, Мөрдөн байцаах газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, Баян-Өлгий аймгийн цагдаагийн газар, Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны төв, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт тус тус явуулав.

Шалгалтаар 321 зөрчил илрүүлснээс 120 зөрчлийг газар дээр нь засуулж, 62 алба хаагчид үүрэг, зааварчилга өгч, гарсан зөрчил дутагдлыг арилгах талаар цагдаагийн 13 нэгж, бусад 16 албадад үүрэг, ажлын чиглэл өгч, санхүүгийн хяналт шалгалтаар 2.3 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлэн, 703.0 сая төгрөгийн зөрчлийг арилгууллаа.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар ажлын байрны зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн 44 алба хаагчийн цалинг бууруулах, 3 алба хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулан, 19 алба хаагчийн албан тушаалыг бууруулж, 4 алба хаагчийн ажлын байрыг өөрчилсөн байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажилд сар бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 7 заалт бүхий зөвлөмжийг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлж, биелэлт үр дүнг тооцлоо.

Засгийн газрын нэгдсэн цахим хуудасны 5 дэд цэсний 18 ангилалд мэдээлэл байршуулахаас Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудсанд төсөв, санхүү болон худалдан авах ажиллагаатай холбоотой 6 төрлийн 116 мэдээллийг байршуулсаны зэрэгцээ худалдан авалтын тухай мэдээллийг журмын дагуу тухай бүр нь байршуулав.

Хүний нөөцийг оновчтой зөв байршуулах, ойрын хэрэгцээг тодорхойлох, нөөцийг бүрдүүлэх чиглэлээр цагдаагийн байгууллагын шинэчлэлийн бодлоготой уялдуулан бүтцийг өөрчлөн батлуулах ажлыг тухай бүр хийж ажилсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын даргын 400 тушаал гаргаж, 8949 алба хаагчийн асуудлыг шийдвэрлэсэн.

Үүнээс бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр 1462, шилжүүлэн буюу зохицуулан томилсон 675, цагдаагаас офицерын бүрэлдэхүүнд 123, газар, хэлтэс, тасгийн даргаар томилогдсон 169, жинхэнээс ахлахаар 154, албан тушаалд нь жинхлүүлэн томилсон 43, нөөцөөс 8, 23 алба хаагчийг шууд томилсон бөгөөд 585 алба

хаагчийн 3607 хуудас хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хариу авч ажилласан байна.

Хууль сахиулахын их сургууль, ОХУ, БНТУ-ын цагдаагийн академийн төгсөгч 190, эргүүлэн томилсон 11, хүүхэд асрах чөлөө цуцалсан 53, түдгэлзүүлснийг цуцалсан 1, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн 8, цуцалсан 11, албан тушаал бууруулан томилсон 70, албан тушаал бууруулж цагдаагаар ажиллуулсан 17 алба хаагч байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр өөрийн хүсэлтээр 78, өөр албанд 31, гачигдлаар 1, эмнэлгийн магадлагаагаар 2, сургуульд суралцуулахаар чөлөөлсөн 19, хүүхэд асрах чөлөөгөөр 68, тэтгэвэрт гаргахаар 91 алба хаагчийг ажлаас тус тус чөлөөлж, хөдөлмөрийн гэрээ цуцалсан 1, чөлөөлсөн 14, 6 алба хаагчийг данс бүртгэлээс хасчээ.

Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, иргэдэд цагдаагийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах газар, Төв архивын газар, Сургалтын төв, Авто бааз, Сүүж-Уул сувилал, Хамгаалалтын хоёр, гуравдугаар газар, Улаанбаатар хотын цагдаагийн газар болон дүүрэг дэх цагдаагийн 16 хэлтэс, Багахангай дүүрэг дэх цагдаагийн тасаг, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хэнтий зэрэг 16 аймаг дахь цагдаагийн газрын орон тоонд тус тус өөрчлөлт оруулан зохион байгуулалтын бүтцийг баталж, Мэдээллийн технологи, холбооны газар, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрыг шинээр байгууллаа.

Сургалтын төв, Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааны төв, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтэс, Орхон аймаг дахь цагдаагийн газрын гэрээт цагдаагийн хэлтэс, Хэвлэл, мэдээллийн төв, Замын цагдаагийн алба, Төмөр зам дахь цагдаагийн газар, Ховд аймаг дахь цагдаагийн газар болон зарим аймаг дахь цагдаагийн газарт Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх “хэсэг” байгуулж, Авто баазын дарга, Хангалт, үйлчилгээний төвийн зарим алба хаагчдын цалингийн зэрэглэлийг өөрчлөв.

“Монгол банк”-ны төв байр, Чингис хаан олон улсын нисэх буудлын нийтийн эзэмшлийн бүс, Баян-Өлгий аймгийн “Цагааннуур чөлөөт бүс”-ийг цагдаагийн байгууллагын хамгаалалтад байх улсын онц чухал объектын жагсаалтад оруулсантай холбогдуулан Хамгаалалтын нэгдүгээр газрын Дипломат байгууллага хамгаалах хэлтэст Банк хамгаалах гэрээт цагдаагийн тасаг, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс, Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газарт гэрээт хэсгийг байгуулсан.

Тахарын ерөнхий газар татан буугдаж, зарим чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Мөрдөн байцаах газрын Эрэн сурвалжлах хэлтэс /ҮII/-т Оргон зайлсан яллагдагчийг эрэн сурвалжлах тасгийг, Хамгаалалтын нэгдүгээр газарт Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийг, нутаг дэвсгэрийн зарим цагдаагийн газар, хэлтэст Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийг тус тус байгуулж, алба хаагчдыг томилов.

Монгол Улсын Засгийн газрын 86 дугаар тогтоолын дагуу аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 79 алба хаагчид 30 сарын тэтгэмж, албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй ердийн өвчнөөр нас барсан 7 алба хаагчийн ар гэрт 36 сар, албан үүргээ гүйцэтгэж байгаад нас барсан 6 алба хаагчийн ар гэрт 60 сар, 2 алба хаагчид буцалтгүй тусламж, цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгосон 58 алба хаагчид 36 сарын тэтгэмж, 15 алба хаагчид 18 сарын тэтгэмж, 7 алба хаагчид нөхөн олговрыг олгожээ.

Эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан алба хаагчдаас төрийн одон медалиар 190, Хууль зүйн яамны шагналаар 304, Цагдаагийн байгууллагын хүндэт тэмдэг 1, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 223, “Хүндэт жуух бичиг”-ээр 318, “Баярын бичиг”-ээр 446, “Спортын алдар” тэмдгээр 17, “Цагдаагийн

төлөө тэмдэг”-ээр 19, “Албаны төлөө-I” медалиар 577, “Албаны төлөө-II” медалиар 816, “Албаны төлөө-III” медалиар 1244, сарын үндсэн цалингийн тодорхой хувиар 192 алба хаагчийг шагнаж, урамшуулжээ.

Үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 37 алба хаагчийг албанаас дутагдлаар халж, 13 алба хаагчид сануулж, 76 алба хаагчийн сарын цалинг төрийн албаны тухай хуулийн дагуу сарын үндсэн цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн хурандаа 21, дэд хурандаа 41, хошууч 52, ахмад 63, ахлах дэслэгч 120, дэслэгч 71 цол алба хаагчдад олгож, бусад байгууллагаас халагдсан болон чөлөөлөгдсөн 16 алба хаагчийн албан тушаалын цолыг хураав.

Алба хаагчдад албаны үнэмлэх олгох ажлыг 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, нийт 10350 алба хаагчдын албаны үнэмлэхийг шинэчлэн олгож, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 916.2.6–д заасны дагуу үнэмлэхээ гээгдүүлсэн 44 алба хаагчид 419.000, энгэрийн тэмдэг гээсэн 34 алба хаагчид 498.000, нийт 917.000 төгрөгийн төлбөрийг төлүүлж, хариуцлага тооцсон байна.

ЦЕГ-ын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар офицерын албан тушаалын нөөцөд 291, ахлахын албан тушаалын нөөцөд 186, хэсэг, тасгийн даргын албан тушаалын нөөцөд 103, хэлтсийн даргын нөөцөд 64, газрын даргын нөөцөд 14, бүгд 658 алба хаагчийг нөөцийн санд бүртгэж, тогтоолоор баталгаажуулан, 60 алба хаагчийг дэвшүүлэн томилсон.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргын 2016 оны 01, 07 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалын сул орон тоог иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулж нөхөх мэргэшлийн шалгалтын комисс, туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, шалгалтыг 2016 оны 03, 11 дүгээр саруудад зохион байгуулж, нийт 593 иргэнийг нөөцөд бүртгэн, 425 иргэнийг Хууль сахиулахын их сургуулийн харьяа Ахлагчийн сургуульд суралцуулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн бага цолны албан тушаалд тус тус томилов.

Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж, мөрдөх журмын тухай, Дотоодын цэргийн тухай, Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж, мөрдөх журмын тухай, Галт зэвсгийн тухай, Терроризмтой тэмцэх тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Цагдаагийн албаны тухай хуульд заасан хориглох зүйлтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд хүлээлгэх хариуцлагыг тусгав.

Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан Монгол Улсын иргэний харьяаллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг 10 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус тус санал боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Монгол Улсын хууль 109, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2, Улсын Их Хурлын тогтоол 2, Засгийн газрын тогтоол 36, Хууль зүйн сайдын дангаар болон хамтарсан тушаалаар баталсан эрх зүйн акт 48, Цагдаагийн ерөнхий газрын тушаалаар баталсан гадагш чиглэсэн эрх зүйн акт 10 нийт 207 хууль, тогтоомж нь бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаад мониторинг, судалгаа хийсэн тайлан, танилцуулгын дагуу хууль тогтоомжид

нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан яам болон холбогдох газруудад нь хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 22-д нэмэлт, өөрчлөлт оруулан, 6 журмыг шинэчлэн боловсруулж, цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэн, байгууллагын дотоод сүлжээ /system.police.gov/-д байршуулж санг тухай бүр шинэчлэн, уг журмын цахим хувилбарыг гар утасны програм хангамж /mobile application/-аар цагдаагийн алба хаагч, ажилтанд ашиглах боломжоор хангах програм хангамжийг нэвтрүүлэхэд бэлэн болгож, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын /код 103, 701/-д нэмэлт, өөрчлөлт оруулаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны заавар”-т нэмэлт оруулах А/59, гэрчилгээний загвар батлах тухай А/14 дүгээр тушаалыг тус тус баталж, Хууль зүйн яаманд хүргүүлэн, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүллээ.

Мөн ЦЕГ-ын даргын 2016 оны А/36 дугаар тушаалаар “Цагдаагийн ерөнхий газрын Тусгай ажиллагааны газрын дүрэм”, “Тусгай ажиллагааны алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт”-ийг, Б/311 дүгээр тушаалаар “Шуурхай удирдлагын болон шуурхай штабын бүрэлдэхүүн, түүний ажиллах чиг үүрэг”-ийг тус тус батлан хэрэгжүүлж байна.

“Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан А/40, 113 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд Улсын ерөнхий прокурорын газартай хамтран “Эрх хязгаарлах арга хэмжээний журам”, “Хууль сахиулагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэх журам”-ын төсөл боловсруулав.

Эрүү, иргэн, захиргааны 59 хэрэгт хариуцагч, нэхэмжлэгчээр оролцож, хариу тайлбар, нэхэмжлэл, нотлох баримт хүргүүлж, 29 удаа давж заалдах болон хяналтын гомдол бичгээр гаргаж, шүүхээр шийдвэрлүүлсэн бөгөөд шүүхээс 83,8 хувийг нь цагдаагийн байгууллагын хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн.

Зэвсэгт хүчний жанжин штабын орлогч даргын 2016 оны 2/889 дугаар албан бичгийн дагуу Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний VI ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтад нийт 28 алба хаагч тэнцэж тус улсад үүрэг гүйцэтгэж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд цагдаагийн алба хаагчдыг оролцуулах бэлтгэл ажлын хүрээнд “Нарстайн ам” дахь хээрийн сургалтын төвийн байрлалд 56 алба хаагчийг сургалтад хамруулсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газраас НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд анх удаа бие даан цагдаагаар үүрэг гүйцэтгэхээр болж нийт 4 алба хаагч Өмнөд Судан, Афганистан улсыг зорьсон.

Түүнчлэн Өмнөд Судан Улсад НҮБ-ын мандатаар Олон Улсын Энхийг дэмжих ажиллагааны 5 дугаар ээлжийн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд 27 алба хаагч оролцож үүрэг гүйцэтгэн ирсэн бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын удирдлага хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны Б/38 дугаар тушаалаар батлсан “Цагдаагийн байгууллагын 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх” ажлын хүрээнд “Монгол цагдаа 95” спортын аварга шалгаруулах цогцолбор 17 төрлийн тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд давхардсан тоогоор 433 байгууллагын 3581 алба хаагч хамрагдаж, нийлбэр дүнгээр 1, 2, 3 дугаар байр эзэлсэн цагдаагийн газар, хэлтсийг prius маркийн автомашин, иж бүрэн компьютерээр шагнаж урамшуулаа.

“Монголын бүх ард түмний спортын 14 дүгээр их наадам” болон олон улс, улс, бүсийн чанартай спортын уралдаан, тэмцээнд цагдаагийн алба хаагчид оролцож 66 /15 алт, 27 мөнгө, 26 хүрэл/ медалиар шагнагдав.

Бразилийн Рио Де Жанейро хотноо 2016 оны 08 дугаар сарын 05-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Олимпын XXXI дэх удаагийн наадамд спортын 5 төрлөөр 8 алба хаагч, Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ойн үндэсний бөхийн барилдаанд 24, сурын харваанд 11 алба хаагч цагдаагийн байгууллагыг төлөөлөн амжилттай оролцлоо.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд ”Эрүүл агаар эм” сэдэвт спорт явган аялалд Улаанбаатар цагдаагийн хүрээний газар, хэлтсийн 31 байгууллага 87 удаа давхардсан тоогоор 6486 алба хаагч хамрагдсан.

2016 онд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн удирдах албан тушаалтанд иргэд, байгууллагаас 9306 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 315 нэгж буюу 3.3 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 211 буюу 2.3 хувь нь санал, 8881 буюу 95.4 хувь нь өргөдөл, 214 буюу 2.3 хувь нь гомдол байна.

*Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл:* 1232 буюу 13.2 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 324 буюу 3.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1497 буюу 16.1 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2305 буюу 24.8 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 422 буюу 4.5 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 3526 буюу 37.9 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.

Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой нийт 1705 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 120 нэгж буюу 6.6 хувиар буурч, 1913 алба хаагч холбогдсоны 1584 буюу 82.8 хувь нь офицер, 320 буюу 16.7 хувь нь ахлагч, 9 буюу 0.5 хувь нь энгийн ажилтан байх бөгөөд нийт өргөдөл гомдлын 1650 буюу 96.8 хувийг барагдуулж, 55 буюу 3.2 хувь нь ажиллагаанд байна.

*Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 61* буюу 3.6 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 98 буюу 5.7 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 7 буюу 0.4 хувь нь хэргийн хугацаа хэтэрсэн, 75 буюу 4.4 хувь нь бусдыг чирэгдүүлж танил тал харсан, 10 буюу 0.6 хувь нь хээл хахуул, шан харамж авсан, 418 буюу 24.5 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 107 буюу 6.3 хувь нь бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 194 буюу 11.4 хувь нь ажлын хариуцлага алдсан, 44 буюу 2.6 хувь нь архидан согтуурсан, 6 буюу 0.4 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 685 буюу 40.2 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль дүрэм зөрчсөн, зөрчлүүд эзэлж байна.

*Сахилгын арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл*: Эрүүгийн хэрэг үүсгэхээр шилжүүлсэн 52, албанаас халсан 23, цол бууруулсан 4, цалин бууруулсан 345, сануулсан 111, алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдоогүй 1189, нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан 21 байна.

2016 онд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 554 санал хүсэлт, гомдол, таархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 210 буюу 38.0 хувь нь санал хүсэлт, 244 буюу 44.0 хувь нь гомдол, 78 буюу 14.1 хувь нь таархал, 19 буюу 3.4 хувь нь шүүмжлэл, 3 буюу 0.5 хувь нь өргөдөл байна. Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, таархал, шүүмжлэл, өргөдлийн 464 буюу 83.8 хувийг шийдвэрлэж, 90 буюу 16.2 хувь нь ажиллагаанд байна. Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 168 буюу 30.3 хувийг 5 хоногийн дотор, 386 буюу 69.7 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэсэн.

Цагдаагийн байгууллагын 1208 алба хаагчдаас ажлын ачаалал, гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан үүссэн сэтгэлийн түгшүүр, стрессийн илрэл, сэтгэл гутралын түвшинг тогтоох зорилгоор судалгаа авч, дүгнэлт гарган, сэтгэл санааны төлөв байдлын сөрөг үнэлгээтэй тодорхойлогдсон 117 алба хаагчтай сэтгэл зүйчдийн баг тусгайлан уулзаж зөвлөгөө өгч, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн.

*Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилтийн талаар:*

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж, 2016 оны байдлаар дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

*Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:* Шуурхай удирдлагын төвийн хоногийн нөхцөл байдлын мэдээтэй өдөр бүр танилцаж, эрүүгийн хэргийн шалгалтын явц байдал, шийдвэрлэлтэд хяналт тавьж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яаманд танилцуулгыг тухай бүр хүргүүлэн, мэдээ, мэдээллээр хангав.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр” боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны өдрийн А/03 дугаар тушаалаар баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хүргүүлж хяналт тавьж ажиллаа.

Монгол Улсын Засгийн газраас Канад Улсын талд хууль зүй, шүүхийн салбарын хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах хүсэлт тавих үед “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх” /500.0 сая төгрөгийн өртөгтэй/ дэд төсөл, АНУ-ын Төрийн Департмент, Олон улсын мансууруулах бодис, хууль сахиулах үйл ажиллагааны харилцааны товчоогоор (INL) дамжуулан Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах зохион байгуулалт, зохицуулалтыг сайжруулах, хууль зүйн салбарын чадавхыг бэхжүүлэх зорилго бүхий “Монгол улс дахь жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хууль зүйн салбарын чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн төсөл /200.000.000 төгрөгийн өртөгтэй/ “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх-Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” дэд төслийг боловсруулан тус тус хүргүүлсэн.

Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 2016-2020 онд 1 тэрбум төгрөгний санхүүжилттэй төсөл хөтөлбөр, Щвейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд судалгааны ажлыг хийж, нэгдсэн мэдээлэл, лавлагааны сантай болох хэрэгцээ шаардлагыг судлах болон дэд төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин Сайдын Яамны дэмжлэгтэй “Монгол дахь жендерт суурилсан хүчирхийллийг зогсоох нь” төслийн хүрээнд АНУ-аас гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн чиглэлээр мэргэшсэн экспертүүд цагдаагийн алба хаагчдад туршлага судлах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх уулзалт, сургалтыг хамтран зохион байгуулаа.

Мөн Монгол Улс дахь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн гадаад, дотоод нөхцөл байдал үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх түвшинд хүрсэн эсэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй арга барил, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаарх танилцуулгыг боловсруулж Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын 2016 оны төсөвт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардал тусгагдаагүйгээс эрүүгийн хэргийг нотлох ажиллагаанд хүндрэл

үүсч байгаатай холбогдуулан Сангийн сайдын 2014 оны “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилалд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардал”-ыг шинээр тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар дамжуулан сангийн яаманд уламжлуулж, зохих албадтай хамтран ажлын хэсэг байгуулан ажиллаа.

2016 онд “Илрүүлэлт-Оргодол”, “Сар шинэ”, “Устгал”, “Бодис”, “Шийдвэрлэлт”, “Тулгалт”, “Автомат тоглоом-2”, “Зэвсэг”, “Уринш”, “Хуурамч мөнгөн тэмдэгт”, “Цохилт”, “Бүртгэл” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг төлөвлөгөө удирдамжийн дагуу улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцов. Мөрийтэй тоглоом ажиллуулж байгаа газруудыг илрүүлэх зорилгоор “Автомат тоглоом-2” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, хууль бусаар мөрийтэй тоглоом зохион байгуулсан 7 байгууллага, иргэнийг эрүүгийн хариуцлагад татаж, энэ талаар хүүхэд, залуучуудад урьдчилан сэргийлэх зорилгоор MNTV-ээр иргэд, олон нийтэд мэдээллийг хүргүүлэв.

Прокурорын байгууллагаас 2015 онд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст бичсэн нийт 216 прокурорын шаардлага, түүний мөрөөр зохиосон ажил, явц үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж, 12 заалт бүхий ажлын чиглэл боловсруулан төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэн, үр дүнг тооцон ажиллав.

Аймаг, нийслэлийн хэмжээнд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн, иргэний танхимын ажилтнууд болон иргэдийг хамруулан “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг тус тус зохион байгуулж, илтгэлийг хэлэлцэн, иргэдийн санал хүсэлтийг сонсч, гаргасан илтгэл, зөвлөмжийг хэвлүүлэн, хүргүүлсэн.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран 02 дугаар сарын 19-ний өдөр Ховд аймагт байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, түүний дотор зэрлэг амьтдын хууль бус агнууртай холбоотой хэргийн талаарх сургалт, зөвлөгөөнд, мөн 2016 оны 05 дугаар сарын 19-ний өдөр “Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах” сэдэвт төслийн уулзалт, хэлэлцүүлэгт удирдлагын төлөөлөл тус тус оролцож, хамтран ажилласан байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлт бүлэгт багтах хүмүүсийн судалгааг хийж, “Хүн худалдаалах цахим санд” хохирогч, холбогдогч нарын нийт 43 иргэнийг бүртгэж, гадаад улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдсон Монгол Улсын 10 иргэний ар гэрийг олж тогтоон мэдэгдэж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон, тухайн улсдаа эрх ашиг нь зөрчигдсөн, тусламж хүссэн 3 иргэнийг БНСУ, БНХАУ-аас аюулгүй авчрах ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гадаад харилцааны яамны Консулын газартай хамтран зохион байгууллаа.

Бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэргийн талаар харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллахаар “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-тэй гэрээ байгуулан хамтран ажиллаа.

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй алба хаагчдын нэгдсэн удирдлагаар хангах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах зорилгоор цагдаагийн фэйсбүүк /www.facebook.com/policemng/ хуудсанд “CYBER DIVISION” нэртэй нууц группийг үүсгэж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс ирүүлсэн мэдээллийг солилцох, зөвлөгөө, зааварчилга өгөх нөхцөл боломжийг бүрдүүлэв.

“Мааз” студитэй хамтран цахим /шуудангийн луйвар, интернет залилан, секс сүрдүүлгийн зэрэг/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 4 ширхэг дүрс бичлэгийг монгол хэлнээ хөрвүүлэн “Цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба” нэртэй фэйсбүүк хуудсанд

байршуулан олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж, оюуны өмчийн зөрчилтэй 5 сайтын эрхийг хязгаарлах хүсэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд тавьж хандалтыг зогсоосон.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баруун бүсийн зөвлөгөөнийг Говь-Алтай аймагт “Улсын хэмжээнд бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал” сэдвээр 2016 оны 03 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулав.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд мөрдөгдөх “Мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах аргачилсан журам”, “Эрэн сурвалжлах нууц ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагуудын хамтран ажиллах журам”-ын төсөл, түүнийг дагалдаж гарах маягтуудыг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Улаанбаатар хотын цагдаагийн газар, Монголын Үндэсний олон нийтийн телевизийн “Эрэн сурвалжлах” нэвтрүүлгийн багтай хамтран Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн замаар алдагдсан эд зүйлсийг худалдан авч, зарж борлуулж буй ченжийн талаар тусгай сурвалжлага хийлгэн иргэд, олон нийтэд хүргэлээ.

“Хөршийн хяналт хөтөлбөр”-ийн хүрээнд Улаанбаатар хотын цагдаагийн газраас Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллага иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/77 дугаар захирамжаар “Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр” төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллав.

“Асап” сангийн ашиглалтад хяналт тавьж ажиллах, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг шуурхай илрүүлэх, урьдчилан сэргийлэх, шалгаж шийдвэрлэх ажлын үр дүнг дээшлүүлэх, нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж ажиллах чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудын удирдлагад үүрэг чиглэл хүргүүлсэн.

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газартай “Террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, улсын хил нэвтрэх зорчигчдод хяналт тавих зорилгоор “Мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээ”-г Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газартай байгуулж, дээрх ажлын хүрээнд хилийн боомтоор нэвтрэгсдийн бүртгэл, хяналтын мэдээллийн шинэ ISM системийг “Асап” сантай холбохоор зөвшилцөн ажиллаж байна.

Монгол Улсад оршин сууж байгаа терроризмын өндөр эрсдэл бүхий 19 улсын 3291 иргэний судалгааг шинэчлэн гаргаж, дээрх иргэдийн оршин сууж байгаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт хяналт тавьж ажиллах үүргийг хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллав.

Улсын хэмжээнд болон интерполоор эрэн сурвалжлалт зарлагдсан түүх соёлын хосгүй үнэт зэрэглэлийн 8, үнэт зэрэглэлийн 49, бусад зэрэглэлийн нийт 386 түүх соёлын дурсгалт зүйлс, Төв, орон нутагт эртний эдлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 89 ченжийг бүртгэл судалгаанд авч, хяналт тавин ажиллаж байна.

ХЗДХЯ, “Цагаан соён” ТББ-тай хамтран “Мансууралгүй ирээдүй” аяныг 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 45 хоногийн хугацаатай зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус 12 байгууллагын 850 ажилтанд 36 цагийн, 6 их дээд сургуулийн 1680 оюутан, ерөнхий боловсролын 7 сургуулийн 910 сурагч, 270 эцэг эх, асран хүмүүжүүлэгчдэд нийт 39 цагийн сургалтыг тус тус зохион байгуулав.

Залилан мэхлэх болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр С1 телевизтэй хамтран 20 минутын сурталчилгааны мэдээлэл бэлтгүүлэн Номин их

дэлгүүр, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Худалдаа хөгжлийн банкны гаднах самбар болон арилжааны банкнуудад байрлах дэлгэцүүд, идэвхтэй ажилладаг 10 цахим сайтаар иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулав.

Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран Ан агнуурын тухай, Ойн тухай, Ашигт малтмалын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 минутын шторк бэлтгэж, энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл хүлээн авах утасны дугаар бүхий боршур /200 ширхэг/-ыг хэвлүүлэн, олон нийт цуглардаг газруудад байршууллаа.

Мөн хууль бус ан агнах, мод бэлтгэх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус бүр 20-28 секундын шторк бэлтгэн төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлэн, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчилан, ажиллах чиглэл өгсөн.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэнд, спортын яам, Гааль, татварын ерөнхий газар, Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, “Цагаан соён” төрийн бус байгууллагатай хамтран энэ оны 04 дүгээр сарын 27-ноос 28-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд “Мансууралгүй ирээдүй” сэдэвт өдөрлөгийн арга хэмжээг амжилттай зохион байгуулж, уг арга хэмжээний талаар МҮОНРТ-ээр олон нийтэд мэдээлэл хүргэсэн.

Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар, БНХАУ-ын НАХЯ, Өвөр Монголын өөртөө засах орны Нийгмийг аюулаас хамгаалах танхимын хамтын ажиллагааны хүрээнд манайд хар тамхи, мансууруулах бодисыг хэргийн газарт богино хугацаанд шинжлэх хүчин чадалтай /зориулалттай/ олон улсад ашиглагддаг “TruNarc” гар багаж 3 ширхэг, мөн хэргийн газарт хойшлуулшгүй ажиллагааны үед ул мөр бэхжүүлэх, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах тест бүхий иж бүрдэл цүнх хоёр ширхэгийг тус тус буцалтгүй тусламжаар олгосныг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

*Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:* Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд тоон үзүүлэлтээр 1038050 /давхардсан тоогоор/ захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 385038 буюу 27,1 хувиар буурсан байна. Зөрчил гаргасан 1001379 иргэн, 107 албан тушаалтан, 1167 байгууллага, аж ахуйн нэгжийг, нийт 30617357,1 мянган төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ авснаас торгуулийн хуудсаар 9276939 зөрчлийг 16749224,1 мянган төгрөгөөр, шийтгэврээр 73740 иргэн, 107 албан тушаалтан, 1167 байгууллагыг 138868133,0 мянган төгрөгөөр тус тус торгов.

Тайлангийн хугацаанд зөрчил гаргасан 30017 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, шүүгчийн захирамжаар 5380 иргэнийг баривчлуулж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 87358 иргэнийг саатуулж, 393 иргэнийг архины албадан, 755 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулав.

Цагдаагийн байгууллагын захиргааны хяналтад 2016 онд нийт 3557 иргэн байгаагаас шүүхээс тэнсэн суллагдсан 2200, хорих ялаас тэнсэн суллагдсан 8244, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 134, жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 75, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 60, хорих ялын хугацаа дуусч суллагдсан 269 иргэн байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор нийт 11245 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж зааварчилга өгч ажилласнаас тэсэрч, дэлбэрэх бодис үйлдвэрлэдэг, хадгалдаг 145, банк, банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх 1123, үйлчилгээний 5026, их, дээд 289, ерөнхий боловсролын 978 сургууль, цахим тоглоомын 1213, асрамж, халамжийн төв 45, бусад 7871 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдлаа.

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 31578 мэдэгдэл, шаардлага, зөвлөмж өгч 30489 хариуг хүлээн авсан. Мөн алба хаагчид нийт 456179 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 1038050 зөрчил илрүүлсэн бөгөөд улсын хэмжээнд давхардсан тоогоор 349 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллаж, 687 зөрчлийг илрүүлж, 528 иргэнийг 3256000 төгрөгөөр торгов.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1819 удаагийн яриа, сэрэмжлүүлгийг давхардсан тоогоор 92456 хүнд хүргэсэн.

Сонгуулийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1 дэх хэсэгт заасны дагуу Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Мөнхийн үсэг” ХХК-ий хэвлэх үйлдвэрт сонгуулийн саналын хуудас хэвлүүлэх үеийн хамгаалалтыг Сонгуулийн ерөнхий хороо, Тагнуулын ерөнхий газар, Улаанбаатар хотын цагдаагийн газрын холбогдох албан тушаалтнуудын хамт үзлэг шалгалт хийж, 2016 оны 06 дугаар сарын 13-24-ний өдрийг хүртэл 6 алба хаагч 24 цагаар хамгаалалтын үүрэг гүйцэтгэлээ.

Сонгуулийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасны дагуу 1998 хэсгийн хорооноос 2179 зөөврийн битүүмжилсэн хайрцгаар 25242 сонгогчийн саналыг авах үеийн хамгаалалтад 1485 алба хаагч, санал авах байрны хэв журмын хамгаалалтад нийт 2366, нэмэгдлээр 631 алба хаагч зөрчил, дутагдалгүй ажилласан.

Сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр буюу 2016 оны 10 дугаар сарын 19-ний өдөр улсын хэмжээнд автомашинт эргүүлийн 149 чиглэлд 286, явган эргүүлийн 296 чиглэлд 589 алба хаагч, бэлэн байдалд 789, санал авах байранд нэмэгдлээр 683 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэв.

Сонгуулийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу аймаг, нийслэлийн засаг даргаас санал авах өдөр согтууруулах ундаа худалдан, үйлчлэхийг хориглосон захирамжийг зөрчсөн Баянгол дүүргийн 22 хороо “Хулан-эрдэнэ”, 9 хороо “Хан” зочид буудал, Дархан-уул аймагт “Хосшагай”, “Дархан хүнс” ХХК-ий хүнсний дэлгүүр зэрэг нийт 4 аж ахуйн нэгжийг илрүүлэн хариуцлага тооцсон.

Сонгуулийн санал хураалтын ирц бүрдээгүйтэй холбогдуулан 291 хэсгийн хороог үргэлжлүүлэн цагдаагийн хамгаалалтад авч, 1795 хэсгийн хорооны саналын хуудас, санал тоолох төхөөрөмж, дагалдах хэрэгслийг хэсгийн хороодод хүргэх үеийн хамгаалалтын үүрэг гүйцэтгэсэн.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хатуу хучилттай зам дагуу орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн замын цагдаагийн болон хэв журмын алба хаагчдыг оролцуулсан “Хөдөлгөөнт эргүүл”, “Оюутан тээвэр” нэгдсэн арга хэмжээг оюутан, сурагчдын зуны амралт, хичээлийн шинэ жил эхлэх үетэй холбогдуулан Авто тээврийн үндэсний төвтэй хамтран 2 үе шаттай, зохион байгуулж дүгнэв.

Намрын ургац хураалтын үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор ХААХҮЯ, ЦЕГ-ын дарга нарын баталсан удирдамжийн дагуу “Ургац-2016” нэгдсэн арга хэмжээг энэ оны 09,10 дугаар сард Хэнтий, Төв, Дархан-Уул, Булган аймгууд, Багануур, Налайх, Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 522 жолооч, нийт 18665 зөрчил илрүүлж, 13987 тээврийн хэрэгслийн жолоочийг 472,150,200 төгрөгөөр торгов.

Нийслэлийн хэмжээнд нийт 1034827 зөрчил илрүүлснээс, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 19641, хөдөлгөөнд оролцох боломжгүй 3430 зөрчлийг тус тус илрүүлж, 965924 хүнийг 21,065,852,800 төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.

Зам тээврийн гэмт хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг арилгуулахаар аж ахуйн нэгж байгууллагад 1799 мэдэгдэл шаардлага хүргүүлж, 1589 хариу авч, 820 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, 138 өдөрлөг, 189 уралдаан тэмцээн, 196 сургууль, цэцэрлэгийн дунд зохиосон арга хэмжээ, 839 сургалт зохион байгуулж, 206 төрлийн

382 зурагт самбар, 289 төрлийн 60336 зурагт хуудас, 353 төрлийн 3164994 санамж, гарын авлага тарааж, осол хэргээс урьдчилан сэргийлэх замын хөдөлгөөний дэг журмыг дээшлүүлэх зорилгоор олон нийтийн байгууллага, иргэдтэй хамтарч 285 лекц, 1103 сургалт, 7043 удаа ухуулга яриа зохион байгуулж, 412427 хүнийг тус тус хамруулаа.

Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилгот хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн 3 дүүргийн нийт 14 газарт хийгдсэн 11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил хийхэд, зорчих хэсгийг бүрэн болон хэсэгчлэн хааж зохицуулалтыг хийж, автозамын тэмдэг тэмдэглэгээ, орц гарц гаргахад саналаа өгч ажилласан.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жил, Замын цагдаагийн алба үүсч байгуулагдсаны 80 жилийн ойг угтсан ажлын хүрээнд шинээр батлагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор “Хөдөлгөөний соёл-бидний оролцоо” уриан дор “Осолгүй жолооч-жаргалтай гэр бүл” сэдэвт аян,“Уран зохицуулагч” тэмцээн, алба хаагчдын сургалт зөвлөгөөнийг баруун болон хойд бүсийн Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай, Хөвсгөл, Булган, Орхон аймгуудад 03 дугаар сард, зүүн бүсийн Баганаар дүүрэг, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгуудад 04 дүгээр сард, төвийн болон говийн бүсийн Төв, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Дорноговь аймгуудад 06 дугаар сард тус тус зохион байгууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны эхний 100 хоногт хийх ажлын төлөвлөгөөний хүрээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Автотээврийн хэрэгсэлд тавигдах техникийн ерөнхий шаардлага стандарт MNS 4598:2011-ийн хэрэгжилтийг хангахаар Автотээврийн үндэсний төвтэй хамтран улсын хэмжээнд 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд автомашины утааны яндан, тээврийн хэрэгслийн шилний гэрэл нэвтрүүлэх чадвар бусад бүрэн бүтэн байдлыг шалгах “Техникийн хяналт, шалгалт” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Арга хэмжээний хүрээнд нийслэлийн хэмжээнд бүрэн бус, улсын дугааргүй, улсын дугаарын тэмдэгтийг нуун далдалсан, бүдгэрсэн, арилсан, утаа ихтэй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн 41,379 жолоочийг 872.268.100 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ авлаа.

Улсын хэмжээнд хөдөлгөөнт эргүүлд ажилласан алба хаагчид нийт 160631 тээврийн хэрэгслийг шалгаж 35172 зөрчил илрүүлэн 28638 иргэнийг 871 282 200 төгрөгийн торгуулийг тасалбараар, 4076 хүнд 196 482 700 төгрөгийн торгуулийг шийтгэврээр, нийт 2947 иргэнд 316.279.000 төгрөгийн торгууль ногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1258 зөрчил илрүүлэн 1008 жолоочийн эрхийг хассан.

Нийслэлийн Тээврийн газартай хамтран 20 аж ахуйн нэгжийн 827 нийтийн зорчигч тээврийн том оврын автобусны утаа, техникийн бүрэн байдалд гэнэтийн шалгалт хийж, 1978 зөрчил илрүүлэн, зөрчлийг арилгуулахаар албан мэдэгдэл, шаардлага хүргүүлэн үр дүнг тооцон ажиллаа.

Автомашины салхины шилний гэрэл нэвтрүүлэх түвшинг тогтоох багаж цагдаагийн байгууллагын хэмжээнд байхгүйгээс энэ төрлийн хяналт, шалгалт хийхэд бэрхшээл учирч байгаа тул шилний гэрэл нэвтрүүлэх байдал болон автотээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын хэмжээг тогтоох 2 төрлийн багажны зардлыг судалж, шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх өдөр”-ийг 4 дүгээр сард “Хүннү молл” худалдааны төв дээр, “Автомашингүй өдөр”-ийг нийслэлийн хэмжээнд 06 дугаар сард

“Автомашингүйгээр цэвэр агаарт хамтдаа”, “Зөвхөн өнөөдөр биш ... Өдөр бүр” гэсэн уриатайгаар зохион явуулав.

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, замын хөдөлгөөний дүрэм, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар, стандарт, гарч байгаа зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, тэдгээрээс үүссэн хохирлын талаар телевизэд 494 нэвтрүүлэг, 2060 сэрэмжлүүлэг мэдээ, 374, радиогийн нэвтрүүлэг, сонин, хэвлэлд 83 нийтлэл, 373 сэрэмжлүүлэг мэдээ, интернет, вэб сайтад 268 нийтлэл, 1242 мэдээ сэрэмжлүүлэг иргэдэд хүргэсэн.

Хууль зүйн сайдын 2013 оны А/121 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай дуут болон гэрэл дохионы журам”-ын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2016 оны 09 дүгээр сард 14 хоногийн хугацаатай “Тусгай дуут болон гэрэл дохио” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, 183 зөрчлийг илрүүлэн, 45 тусгай дуут болон гэрэл дохиог хураан, 78 жолоочийг нийт 4.272.000 төгрөгөөр торгож, зөрчлийг цаашид дахин давтахгүй байхыг анхааруулан 11 мэдэгдэл, шаардлага хүргүүлэв.

2016 онд зам тээврийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 50 хүүхэд нас барсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 7,4 хувиар буурч, орон нутагт 7,1 хувиар өссөн статистик үзүүлэлт гарсанд дүгнэлт хийн ажиллаж байна.

“Хөршийн хяналт хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сурталчлах чиглэлээр Улаанбаатар хотын цагдаагийн газраас нийт 815 хөршийн хяналтын бүлгийг бүртгэлд авч, “Хөршийн хяналтын бүс”, “Камерын хяналт ажиллаж байна” гэсэн бичиглэл бүхий самбар /1000 ширхэг/-ыг гудамж талбайд байрлуулан, 2000 ширхэг “Хөршийн хяналтын бүлгийн гарын авлага” бэлтгэн тараан өгсөн. Мөн хяналтыг сайжруулж орчны аюулгүй байдлыг хангах талаар сайн ажиллаж байгаа туршлагуудын талаар 22 хорооны 4500 гаруй иргэдэд зөвлөгөө өгч, цагдаагийн 760 алба хаагчдад мэдээлэл өгч ажиллаа.

Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гэр хорооллын гудамж, орон сууцны орц, нийтийн эзэмшлийн талбайг "Хөршийн хяналтын бүлэг"-тэй хамтран камержуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажилд шаардагдах 75 сая төгрөгийг нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөр шийдвэрлүүлэн 4 хороог сонгон гүйцэтгэгчээр шалгарсан “Нью-Палкон” ХХК-тай хамтран ажиллаж байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 91, 08 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/609 тоот захирамжийг зөрчсөн болон удаа дараа зөрчил гаргасан нийт 57 аж ахуйн нэгж байгууллагын архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг 8 удаа албан бичгээр нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлж, 47 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 5 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг хүргүүлж, шийдвэрлүүллээ.

“Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг боловсруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, Нийслэлийн Мэдээллийн технологийн газартай хамтран “Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор “Барьцааны бүртгэл, хяналтын систем”, “Барьцааны бүртгэл, хяналтын систем ашиглах журам”-ын төслийг боловсруулж, нэгдсэн хяналтын системийг нэвтрүүлэхэд шаардагдах 82.0 сая төгрөгийн төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэв.

Түүнчлэн Улаанбаатар хотын цагдаагийн газраас Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Ухаалаг цагдаа” төслийг 2016-2017 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг эхний 11 сарын байдлаар 1331 бүртгэгдсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад 102 хэргээр буюу 8,3 хувиар өссөн, бүх хэрэгт эзлэх хувийн жин 5,3 хувь болж, 0,4 нэгжээр өссөн үзүүлэлтэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд 1236 иргэн өртсөний 90.9 хувь нь эмэгтэй хүн байх бөгөөд гэмт хэргийн улмаас 12 хүн нас барж, 1001 хүн гэмтэж, нийт 757,7 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Түр хамгаалах байрны 107 тусгай дугаарын утсанд нийт 7791, өөрийн биеэр ирсэн 103 иргэнийг хүлээн авч уулзаж 1145 иргэнд сэтгэл зүйн, 6543 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 86 мэдээлэл ирснийг бүртгэж, холбогдох газруудад нь шалгуулахаар шилжүүлсэн байна.

Үүрэн телефоны оператор “Мобиком” корпорацитай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор 107 дугаарын утсанд хандаж зөвлөгөө авах талаар сурталчилгаа бүхий мессежийг 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр нийт хэрэглэгчдэд үнэ төлбөргүй илгээн сурталчилсан.

Энэхүү тусгай дугаарын утсыг сурталчилсан 2 төрлийн шторкийг “Үндэсний цуурай” ХХК-тай хамтран бэлтгэж, Өргөө-1, 2, Тэнгис кино театрын дэлгэцээр кино эхлэхийн өмнө иргэдэд хүргэж хэвшсэн.

Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 886 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 155 гэмт хэргээр буюу 14.9 хувиар буурчээ. Үүнээс нийслэл хотод 580 буюу 64.7, орон нутагт 336 буюу 35.3 хувьтай байна.

Албадан саатуулах төвд Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсүүдийн хариуцсан нутаг дэвсгэрт согтуугаар захиргааны зөрчил үйлдсэн 606, Улаанбаатар хотын дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдээс 72 цаг хүртэл хугацаагаар албадан саатуулсан 2204, нийт 2816 иргэнийг хүлээн авч байрлуулан, аюулгүй байдлыг нь хангаж ажилласан бөгөөд албадан саатуулагдсан иргэний тоог урьд оны мөн үетэй харьцуулбал 0,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тус төв нь захиргааны журмаар албадан саатуулагдсан 2204 иргэнд эрүүл мэндийн үзлэг хийн хүлээн авч, давхардсан тоогоор 948 иргэнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, 219 иргэнийг эмчийн байнгын хяналтад авч, өвчний учир хүлээн авах боломжгүй 323 иргэнийг буцаан, яаралтай түргэн тусламжийн төвд 66 удаа дуудлага өгч, 36 этгээдийг харьяа дүүргийн эмнэлэгт хэвтүүлэн, эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэв.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Боловсролын газар, Монголын Сурагчдын холбоотой хамтран “Сургуулийн эргүүл”-ийн 2015 онд зохион байгуулсан ажлын тайлан, мөн эцэг эхчүүдийн уулзалт, чуулганыг 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Хангарьд ордонд зохион байгуулж, арга хэмжээнд дээрх газруудын дарга, удирдлагууд болон цагдаагийн алба хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн 36 захирал, нийгмийн ажилтан, багш нарын төлөөлөл 60, эцэг эхчүүдийн төлөөлөл 30 иргэн тус тус оролцож, эргүүлийг идэвхтэй сайн зохион байгуулж ажилласан нийт 60 хүнийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улаанбаатар хотын цагдаагийн газар, Нийслэлийн Боловсролын газар, Монголын Сурагчдын холбооны шагналуудаар тус тус шагнууллаа.

Нийслэлтийн хэмжээнд 2016 онд 180 дунд сургууль дээр нийт 54720 эцэг, эх эргүүлийн үүрэг гүйцэтгэж хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэргийн улмаас эрх ашиг нь хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан бөгөөд цагдаагийн байгууллагаас Монголын Сурагчдын холбооны “School police” төвтэй хамтран 6 удаагийн хэсэгчилсэн шалгалтыг зохион байгуулж, 78 сургуулийн эргүүлийг

шалгаж, 34 зөрчил илрүүлж, 24 сургуулийн захиргаанд албан мэдэгдэл өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаа.

Олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг Нийслэл, дүүрэг хороодод зохион байгуулагдсан “Хяналт”, “Тарваган тахлаас урьдчилан сэргийлье”, “Хамгаалах бүс”, “Гудамж”, “ТҮЦ”, “Автомат тоглоом”, “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье” зэрэг нэгдсэн 14 удаагийн арга хэмжээ, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, цагдаагийн хэлтсүүдээс дүүрэг, хороодод зохион байгуулсан 325 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээ өдөрлөг, уулзалтад оролцуулж, үйл ажиллагааг 15 телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

Олон нийтийн цагдаагийн ажилтнууд хороодын хэсгийн байцаагч, цагдаа нартай хамтран 58 гэмт хэргийг таслан зогсоож, 4038 аж ахуй нэгж байгууллагад 1566 албан мэдэгдэл, зөвлөмж, санамжийг хүргүүлэхэд оролцон, 205 хэргийн газрын хамгаалалтад ажиллаж, эргүүлээр үүрэг гүйцэтгэх явцдаа 6634 иргэнд хууль тогтоомжийг тайлбарлан таниулж, 360 дуудлага мэдээллийг шалгаж, зөрчил гаргасан 838 иргэний асуудлыг шийдвэрлүүлж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

Олон нийтийн цагдаагийн ажилтнуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор хэсэгчилсэн хяналт шалгалтыг дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд давхардсан тоогоор 68 удаа зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, хангалтаар олгосон техник, хэрэгслийн ашиглалтын байдалд цагдаагийн хэлтсүүдээс 89 удаа үзлэг тооллогыг хийж, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр 224 ажилтнаас давхардсан тоогоор 1321 удаа баталгаа авч, 467 удаа бичгээр зөвлөмж, зааварчилга өгч биелэлтийг тооцов.

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Оюутны холбоотой хамтран “Оюутан цагдаа” арга хэмжээг 3 дахь жилдээ зохион байгуулж, 110 оюутантай хөдөлмөрийн гэрээ байгуулан, хантааз, малгай зэрэг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаж, эргүүлийн 55 чиглэлд үүрэг гүйцэтгүүлэн, үр дүнг тооцон ажиллажээ.

*<u>Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:</u>* 2016 онд зохион байгуулагдсан Сар шинийн “Битүүний өдөр”-ийн барилдаан, Гандантэгчилэн хийдийн хурал, Төр, засгийн тэргүүнүүдийн золголт, ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, гадаад улсын зочид, төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн хувийн болон албан айлчлал, Говь-Алтай аймгийн Бигэр, Төв аймгийн Сүмбэр сумдад хууль бусаар алт олборлож байгаа иргэдийг тараах, Хурдан морины Хангайн бүсийн хаврын уралдаан, “Дүнжингарав-2016” хурдан морины уралдаан”, Зэвсэгт хүчний 95 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”, “Монгол тэмээ 999” уралдаан, “Чингис Мастер кросс-2016”, Олон Улсын жудо бөхийн “Чингис хаан-гранпри” тэмцээн, “Монголын тамирчдын өдөр”, УИХ, аймаг, нийслэлийн ИТХ-ийн сонгууль, Ардын хувьсгалын 95 жил, Үндэсний их баяр наадам, АСЕМ-ын хурал, Дээрхийн гэгээн XIV Далай ламын айлчлал, ОХУ-ын Элчин сайдын яамнаас “ЗХУ-ын маршал Г.К.Жуковын мэндэлсний 120 жилийн ойн өдөр”-ийг тохиолдуулан цэцэг өргөх ёслол, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгууль болон дахин явагдсан сонгууль зэрэг нийт 2198 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээний явцад давхардсан тоогоор 50724 алба хаагч, 5523 автомашинтайгаар 27293 цагийн хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулав.

Мөн нийслэл, орон нутагт зохион байгуулагдсан нийт 121 удаагийн жагсаал, цуглааны хамгаалалтад давхардсан тоогоор 2539 алба хаагч, 208 автомашинтайгаар 1534 цагийн үүрэг гүйцэтгэн ажиллаа.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаан, нийтийг хамарсан арга хэмжээний талаар нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсийн дарга

нарт /шифр 61 удаа/ ажлын чиглэл хүргүүлж, нөхцөл байдлын талаар харилцан мэдээ, мэдээлэл солилцож, хяналт тавьж ажиллав.

Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын хамгаалалтад 1529867 хүн, 352253 тээврийн хэрэгсэл, 51406 вагон нүүрс, экспортод 193131 уут 10362 чингэлэг зэсийн баяжмал, 1648 уут 324 чингэлэг молибдений баяжмал, лабораторид шинжлүүлэх 11971,9 кг зэсийн баяжмал, 1001,5 кг молибдений баяжмал, тэсрэх бодисын үйлдвэрээс 16172,1 тн тэсрэх бодисыг шалган нэвтрүүлж, 327065 хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж, хамгаалалтын бүсэд харуулын цагдаагийн хяналт, шалгалтаар 76 зөрчлийг илрүүлэн шалгаж, 23 иргэнийг байгууллагын захиргаанд мэдэгдэж, захиргааны зөрчил үйлдсэн 53 иргэнийг “Захиргааны хариуцлагын тухай хууль”-ийн холбогдох заалтын дагуу 265.000 төгрөгөөр торгох, саатуулах байранд хүргэх арга хэмжээг авч, захиргааны хэргийн туслах тоо бүртгэлийн мэдээллийн санд бүртгэсэн.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг хэрэгжүүлж, Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасан чиг үүргийн дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн худалдаа, үйлдвэрлэл, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 23 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг үндэслэн 884 удаагийн тээвэрлэлтийн хамгаалалтад давхардсан тоогоор 986 алба хаагчийг томилж, 18 аймаг нийслэлийн 3 дүүрэг, 42 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын уурхайн агуулахад 48398 тн 292 кг тэсэрч дэлбэрэх бодис, 4.094.513 метр, 3.006.722 ширхэг тэсэлгээний хэрэгслийг хүргэх ажлыг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллав.

<u>Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчний талаар:</u> Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчин 21 аймгийн 124 сумын нутагт давхардсан тоогоор нийтдээ 206 удаа гарч, 217452 толгой мал, амьтан өвчилж, 28172 толгой мал, амьтан хорогдсон бөгөөд хамгаалалтад давхардсан тоогоор 18 аймгийн 108 суманд 723 алба хаагч хорио цээрийн дэглэм сахиулсан.

<u>Эрэн хайх, аврах ажиллагааны талаар:</u> Улсын хэмжээнд эрэн хайх, аврах ажиллагааны 653 тохиолдол бүртгэгдэж, 3726 хүний амь биеийг аварч, 81 хүн нас барсан гэсэн мэдээлэл байгаа бөгөөд цагдаагийн байгууллагаас энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай тухай бүр хамтран ажиллаж байна.

*Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:* Тахарын ерөнхий газар татан буугдаж зарим чиг үүрэг нь цагдаагийн байгууллагад шилжин ирсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/437 дугаар тушаалаар Хамгаалалтын нэгдүгээр газарт Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс, нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэст олон нийтийн аюулгүй байдлыг хангах нэгжийн албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг баталж, алба хаагчдыг томилов.

Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 41 шүүхийн байранд 116 шүүх хуралдааны танхим ашиглагдаж байгаагаас цагдаагийн байгууллага дээрх шүүхийн байруудыг 24 цагийн хамгаалалтад авч ажиллаж байна.

2016 онд эрүүгийн 4306, онлайн хурал 66, иргэний 13553, захиргааны 2542 нийт 20401 шүүх хуралдаан товлогдсоноос эрүүгийн 4324, иргэний 6534, захиргааны 1002, нийт 11861 шүүх хуралдааны хэв журмыг сахиулж, шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж 854-г хүлээн авснаас 778 шийдвэр, захирамжийг шийдвэрлэн, 1120 иргэнийг албадан ирүүлж, цагдан хорих байрнаас шүүхийн танхим хооронд нийт 2797 шүүгдэгчийг хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулаа.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга болон холбогдох албан тушаалтнуудтай ажлын уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар харилцан санал солилцлоо.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөлөлтэй хамтран “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын төслийг боловсруулан баталгаажуулж, Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 59/А/67 дугаар тушаалаар батлагдсан “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүллээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан А/40,113 дугаар тушаалаар баталсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ийн дагуу 09 дүгээр сарын 20-ны өдөр 21 аймгийн шүүх, Улаанбаатар хотын шүүхүүдийн дарга удирдлагыг оролцуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн байранд уулзалт зохион байгуулан санал солилцон ажилласны зэрэгцээ нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 7 шүүхийн байртай танилцав.

*Гурав. Дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны талаар:*

*Мэдээллийн сан, статистикийн чиглэлээр:* Гомдол, мэдээллийн санд 466736, түүний шийдвэрлэлтийн мэдээллийн санд 379063 гэмт хэргийн мэдээллийн санд 27873, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн санд 9435, хэрэгсэхгүй болгох саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн санд 18270, түдгэлзүүлсэн хэргийн мэдээллийн санд 9101, сэргээсэн хэргийн мэдээллийн санд 10498, нөхөн илрүүлсэн хэргийн мэдээллийн санд 1360, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаа сунгасан хэргийн мэдээллийн санд 612, прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан хэргийн мэдээллийн санд 2926, нэгтгэсэн хэргийн мэдээллийн санд 2929, зүйлчлэл өөрчлөгдсөн мэдээллийн санд 2146, харьяаллын дагуу шилжүүлсэн мэдээллийн санд 1663, сэжигтний мэдээллийн санд 23677, яллагдагчийн мэдээллийн санд 22014, таслан сэргийлэх арга хэмжээ авсан мэдээллийн санд 14235, хохирогч иргэн, байгууллагын мэдээллийн санд 27785, хохирлын мэдээллийн санд 26501, хохирол нөхөн төлүүлэлтийн мэдээллийн санд 13867, хөрөнгө битүүмжилсэн мэдээллийн санд 1520, туслах тоо бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд захиргааны зөрчлийн мэдээллийн санд саатуулагдсан хүний мэдээллийн санд 81887, торгуулийн хуудсаар торгосон мэдээллийн санд 989838, шийтгэврээр торгосон мэдээллийн санд 102417, захиргааны хяналтад байгаа хүний мэдээллийн санд 1910, албадан саатуулсан мэдээллийн санд 761, түр саатуулсан мэдээллийн санд 2888, албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан иргэний мэдээллийн санд 681, захиргааны зөрчлийн улмаас хохирсон хүний мэдээллийн санд 6210 мэдээллээр тус тус сан бүрдүүллээ.

Сар бүр гэмт хэрэг, захиргааны зөрчлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээ”, “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд шалгагдсан эрүүгийн хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн мэдээ”, “Түдгэлзүүлсэн хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн мэдээ”, гэмт хэрэгт өртөж хохирсон болон гэмт хэрэгт холбогдон шалгагдсан гадаадын иргэд, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн болон хүүхэд үйлдсэн, гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдсан хүүхдийн талаарх мэдээ, танилцуулгыг бэлтгэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, мэдээ, танилцуулгуудыг байгууллагын “Police.gov.mn” цахим хуудас болон дотоод сүлжээ guide.police.gov хаягт тус тус байршуулж, танилцах боломжийг бүрдүүлж ажиллаа.

2015 оны гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд үндэслэн “Мэдээллийн санд гарч буй алдаа дутагдал, цаашид анхаарах асуудал”-аар 21 аймаг дахь цагдаагийн газар, Улаанбаатар хотын цагдаагийн газрын дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлэн, гэмт хэргийн болон туслах тоо бүртгэлийн сан бүрдүүлэлтийг

шалгаж, газар дээр нь алдаа дутагдлыг залруулах, өмнө хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр хийсэн ажилтай танилцах ажлыг 3 удаа зохион байгуулан ажиллав.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас нийт 2858 хүний гэмт хэрэг зөрчлийн учир шалгагдаж байгаа эсэх мэдээллийг шалгаж, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 202, түр оршин суух 142, харьяаллаа сэргээлгэх хүсэлт гаргасан 9, харьяат болох хүсэлт гаргасан 82 хүний цагдаагийн байгууллагад хэрэг зөрчлийн учир шалгагдаж байгаа болон ял шийтгэгдэж байсан эсэх, ялтайд тооцогдож байгаа тухай мэдээлэл бүртгэгдсэн эсэхийг ял шийтгэлийн Лавлагааны сангаас шалгаж, хариуг зохих журмын дагуу хүргүүллээ.

“Иргэний харьяаллын асуудлаар сан бүрдүүлэх, лавлагаа өгөх /код-628/ журам"-д заасны дагуу мэдээллийн санд Монгол Улсын харьяат болох харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 2015 оны 2055 иргэний мэдээллийг нөхөж бүртгэв.

Лавлагааны сан нь сан бүрдүүлэх чиглэлээр давхардсан тоогоор анхан шатны 771 шүүхээс ирүүлсэн 7,376 ширхэг “Ял шийтгэлийн тэмдэглэл”, мөн Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын 2014 оны а/27, 312 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан прокурор, цагдаагийн байгууллагын хооронд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдаж хэрэг нь хэрэгсэхгүй болсон хүний талаарх мэдээлэл солилцох журмын дагуу тус санд давхардсан тоогоор 98 Прокурорын газраас ирүүлсэн 13968 ширхэг маягт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас хорих болон баривчлах төрлийн ял эдлээд суллагдсан 3250 хүний “Ялтны хувийн хэрэг”, “Ялтны судалгааны карт” зэргийг тус тус хүлээн авч нийт 24594 хүний мэдээллийг цахим санд оруулж, цаасан суурьтай баримтуудыг архивлаж цэгцэллээ.

Сангаас лавлагаа өгөх чиглэлээр төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын эрх бүхий алба хаагчдаас болон сүлжээ, шуудангаар ирүүлсэн 73049 ширхэг “Ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас”, “Ялтны хувийн хэрэг”-ээс хуулбар авах хүсэлт гаргасан 4113 албан бичгийг бүртгэн хүлээн авч 687 хүний 4031 ширхэг “Ялтны хувийн хэрэг”-ээс 39790 хуудас шаардлагатай материалыг хуулбарласан, эрх бүхий байгууллагуудаас иргэний ялтай эсэх лавлагаа авахаар ирүүлсэн 2827 албан бичгийн дагуу 37654 хүнийг шалгаж, цагдаагийн “Тодорхойлолт” авахаар хүсэлт гаргасан 82941 иргэдэд тодорхойлолт олгож үйлчилгээний төлбөрийн орлогод /41.115.000/ дөчин нэгэн сая, нэг зуун арван таван мянган төгрөгийг төвлөрүүлэв.

Лавлагааны цахим сангийн мэдээллийг архивын сан дахь мэдээлэлтэй тулгалт хийх ажлын хүрээнд нийт 38716 картыг цахим сан дахь мэдээлэлтэй тулгаж, ямар нэг мэдээлэл нь алдаатай буруу шивэгдсэн 21057 карт дахь мэдээллийг цахим санд засварлан залруулжээ.

Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын төвд иргэдээс нийт 1516355 удаагийн хандалт хийгдсэнээс 99.1 хувь буюу 1502973 дуудлагад хариу өгсний 1461612 буюу 96,4 хувь шууд 42807 буюу 2.8 хувь нь хүлээлгийн горимоос холбогдож, 13382 буюу 0,8 хувь нь ямар нэгэн байдлаар холбогдож чадаагүйд дүгнэлт хийн ажиллаж байна.

Гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн талаарх 454270 мэдээлэл хүлээн авч Улаанбаатар хотын цагдаагийн газрын Мэдээллийн удирдлага, зохион байгуулалтын хэлтэс, нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсүүдэд дамжуулсан.

Үүнд: Архидан согтуурсан 154310, хэв журмын зөрчил 192555, гэмт хэргийн талаарх мэдээлэл 56034, сураггүй алга болсон хүний талаарх мэдээлэл 7959, олдсон хүүхэд /хүн/-ийн талаарх мэдээлэл 6466, цагдаагийн алба хаагчтай холбоотой 700, гадаадын иргэнтэй холбоотой 513 хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 16128,

сонгуультай холбоотой 830, бусад 44276, зам тээврийн ослын 116170 мэдээ, мэдээлэл бүртгэгдсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын http://102.police.gov дотоод цахим хуудасны МШУТ-ийн ШУХ 102-оос анхааруулж байна хэсэгт хулгайлах гэмт хэргийн, хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлагын шийдвэрлэлтийн зөрчилтэй мэдээллийг өдөр бүр байршуулан ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авч, хариу мэдэгдэж байх тухай 489, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн дарга нарт хариуцсан нутаг дэвсгэрт хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлагыг богино хугацаанд шийдвэрлүүлэхээр /давхардсан тоогоор/ 323 албан бичгийг тус тус хүргүүлэн хариуг авсан.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам Монголын дүлий иргэдийн нийгэмлэгтэй хамтран байгуулсан санамж бичгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 512 иргэдийн утасны бүртгэл бүртгэгдсэнээс 102 тусгай дугаарт 4 хэрэглэгчээс 15 дуудлагыг мессежээр ирүүлснийг хүлээн авч шийдвэрлэв.

Монголын дүлий иргэдийн дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын /МДИДО/ “Эхлэл” төвтэй хамтран давтан болон түвшин ахиулах сургалтыг тодорхой хугацааны дараа явуулах, “Цагдаагийн дуудлага” нэвтрүүлгийг сонсголын бэрхшээлтэй иргэд үзэх боломжоор ханган дохионы хэлний орчуулгатай болгох, цагдаагийн байгууллагын алба хаагчдад зориулсан дохионы хэлний анхан шатны мэдлэгийг олгоход зориулсан гарын авлага бэлтгэх зэрэг ажлуудыг төлөвлөж, холбогдох байгууллагуудтай санал солилцон ажиллаа.

АСЕМ-ын бэлтгэл ажлын хэсэг /Гадаад хэргийн яам/-ээс Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн серверт иж бүрэн хөргүүрийн систем худалдан авахад зориулсан 172.6 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж “Синус Дочи” ХХК-иар 12НР-ийн 2 ширхэг, 5НР-ийн хүчин чадалтай 1 ширхэг төхөөрөмжийг төвийн серверийн өрөөнд суурилуулж хүчин чадлыг нэмэгдүүлэв.

Дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн нэгдсэн сүлжээ, дотоод сүлжээний замчлагч төхөөрөмжүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, сүлжээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор судалгаа хийж, АСЕМ-ын хурлын үед ашиглагдаж байсан тоног төхөөрөмжийн жагсаалтад багтаан шийдвэрлүүлж, суурилуулалтын ажлыг зохион байгуулсан.

*Мэргэжил, хяналтын чиглэлээр:* “Байгууллагын ил тод байдлыг хангах /код 134/ журам”-д заасны дагуу тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх дамжаанаас мэргэжлийн шалгалт авах он, сар, өдөр, авто сургууль, дамжааны нэр, шалгалт авах ангилал, байрлал зэрэг мэдээллийг багтаасан шалгалтын хуваарийг Лицензийн төвийн үйлчилгээний танхим болон www.facebook.com/licensepolice цахим хуудсанд байршуулж, иргэдийг мэдээллээр шуурхай ханган ажиллаа.

Нийслэлийн хэмжээнд жолооч бэлтгэх авто сургуулийн нийт 2311, орон нутгийн 3067 элсэлтийн тушаал хүлээн авч бүртгэлд оруулан баталгаажуулж, давхардсан тоогоор 6318 автосургуулийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавив.

Давхардсан тоогоор нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалтад 34460 иргэнээс 14507, автодромд 28619 иргэнээс 20106, замын хөдөлгөөний жолоодлогын шалгалтад 12827 иргэнээс 11714 тэнцэж, нийт давхардсан тоогоор 34460 иргэнийг шалгалтад хамруулснаас 11714 иргэн буюу 33.7 хувь нь тэнцсэн байна.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох шалгалтад тэнцэж шинээр жолооч болсон В ангиллын 51559, ВС ангиллын 2130, ангилал ахиулсан А ангиллын 4309, С ангиллын 10456, Д ангиллын 6591, Е ангиллын 4329, ДЕ ангиллын 632, М ангиллын 1845 иргэний материал хүлээн авч жолоочийн бүртгэлийн нэгдсэн санд оруулав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагуудаас тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах нэмэгдэл ялаар шийтгүүлсэн 402 ялтны материалыг хүлээн авч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй 20 ялтны эрх хасах нэмэгдэл ял оногдуулсныг жолоочийн мэдээллийн сан /TPS/-гийн хар жагсаалтад шинээр жолоодох эрх олгохгүй байхаар бүртгэж, 382 ялтны тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг журамд заасны дагуу санд хасалт хийж, холбогдох газруудад албан бичгээр хариу хүргүүллээ.

Улсын хэмжээнд жолоодох эрх хасагдсан 25641, эрх сэргээх шалгалтад тэнцсэн 12165, зөрчлийн 3413 жолоочийн мэдээллийг жолоочийн бүртгэл, мэдээллийн санд шивж орууллаа.

Иргэдэд олгодог тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн лавлагаа, жолоочийн зурагтай лавлагааг Төрийн үйлчилгээний цахим машинаас авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд тайлангийн хугацаанд нийт 6821 иргэн лавлагаа авсан.

Цагдаагийн албаны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу “Хатан Эрдэнэ” төрийн бус байгууллагатай хамтран “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан, зөрчлийн оноо дуусан жолооч нарт 2 төрлийн сургалтыг лекц, видео хэлбэрээр 6 цагийн сургалтыг өдөр бүр зохион байгуулсан бөгөөд нийт 9689 иргэн хамруулж, давхардсан тоогоор 19277 иргэнээс цахимаар шалгалт авч, тэнцсэн 5757 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг сэргээсэн байна.

Хаясан, гээсэн, ангилал ахиулсан, хуучныг солиулах, нөхөж авах, шинээр үнэмлэх авах, гадаад жолооны үнэмлэх солиулах зэрэг нийт 121890 жолооны үнэмлэх хэвлэж олгосон. Жолооны үнэмлэхний бэлдэц дуусантай холбоотойгоор жолооны үнэмлэхээ хаясан, гээсэн 51707 иргэнд жолоочийн түр зөвшөөрөл олгосон.

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт, жолоочийн үнэмлэх олгохтой холбоотой асуудлаар иргэдээс 72 гомдол, санал шүүмжлэл, байгууллага, аж ахуйн нэгжээс 768 албан бичиг хүлээн авч, 539 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, бусад байгууллагад холбогдох асуудлаар 383 албан бичгийг хүргүүлж, тус төвийн үйлчилгээний танхимаар 166348, Дүнжингарав худалдааны төвд байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөр 8747, нийт 175095 иргэнд үйлчилгээ үзүүллээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.1, Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/189 дугаар тушаалаар батлагдсан “Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам”-ын 2.1.5-д “Цагдаагийн байгууллагын эрх бүхий нэгж нь Монгол Улсын Олон улсын жолоочийн үнэмлэх олгох эрх, үүргийг хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу олон улсын жолооны үнэмлэхийг хэвлэж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 141 дүгээр тогтоолын дагуу Дүнжингарав худалдааны төв дэх “Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-д жолоодох эрхийн шалгалт болон жолоодох эрх сэргээх цахим шалгалт авахад шаардагдах 8 компьютерийг сүлжээнд холбон шалгалт авч эхлэв.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, зардал багатай хүргэх “Цахим болон мобайл технологид суурилсан программ хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийг гэрийн хаягаар нь иргэдэд хүргэх үйлчилгээг Монгол шуудан ХК-тай гэрээ байгуулан 452 иргэнд жолоочийн үнэмлэхийг захиалгаар хүргэх үйлчилгээг үзүүллээ.

*Зөвшөөрөл, хяналтын чиглэлээр:* Галт зэвсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт зааснаар гадаад орнуудаас галт зэвсэг худалдан авах хүсэлт гаргасан 223, улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрөл хүссэн 216, тэмцээн, уралдаанд оролцох зорилгоор улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх, гаргах зөвшөөрөл хүссэн спорт, буудлагын 22 холбоо, ан агнах зорилгоор улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх, гаргах зөвшөөрөл хүссэн 117 иргэн, хуулийн этгээдэд тус тус холбогдох зөвшөөрлийг олгосон.

Галт зэвсэг худалдаж авах, улсын хилээр нэвтрүүлэх хүсэлт гаргасан 364 иргэний ял шийтгэгдсэн эсэх лавлагааг гаргуулан холбогдох судалгааг хийж, гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан 358 ширхэг галт зэвсэг, 54122 ширхэг сумыг Лицензийн төвийн галт зэвсгийн агуулахад байрлуулж, галт зэвсгийн лавлагаа авахаар ирүүлсэн цагдаагийн 38 байгууллагад холбогдох лавлагааг хүргүүлсэн.

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн 11, 12, 15 дугаар зүйлд заасны дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахаар хандсан 69 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн аван судалж, Уул уурхайн яаманд 40 аж ахуйн нэгжийг дэмжих санал хүргүүлж, шаардлага хангахгүй 29 аж ахуйн нэгжид татгалзаж хариуг өгөв.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, овор ихтэй ачаа тээвэрлэх хүсэлт ирүүлсэн 49 аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор нийт 274 тээврийн хэрэгсэлд холбогдох зөвшөөрлийг олгосон ба тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн маршрут, чиглэл батлуулах хүсэлт гаргасан 1012 аж ахуйн нэгж, байгууллагын материалыг хүлээн авч, хянан тээвэрлэлтийн үеийн хамгаалалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 328 аюултай ачаа тээвэрлэсэн тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийжээ.

Хууль зүйн сайдын 2013 оны А121 дүгээр тушаалаар батлагдсан “Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-ын дагуу хугацаа дуусан болон шинээр зөвшөөрөл хүссэн 966 байгууллага, албан тушаалтны хүсэлт, холбогдох материалыг хүлээн авч, хянан 818 байгууллага, албан тушаалтны 1819 тээврийн хэрэгсэлд 3 сараас 1 жил хүртэлх хугацаагаар зөвшөөрөл (Улаан 567, Хөх-Улаан 125, Хөх 137, Ногоон 289, Шар 701) олгож, дээрх журмаар эрх олгоогүй 54 байгууллага, албан тушаалтны хүсэлтэд татгалзсан хариу өгөв.

“Тусгай дуут болон гэрэл дохионы журам”-ыг шинэчлэн боловсруулж, төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, журмын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай “Тусгай дуут болон гэрэл дохио” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд холбогдох журам зөрчиж замын хөдөлгөөнд оролцсон 183 зөрчлийг илрүүлэн ажилласан.

Гэрээт харуул, хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэд, аж ахуй нэгж, байгууллагад цагдаагийн ажил, үйлчилгээг шуурхай хүргэх, мэдээ, тайлангийн бодит байдлыг хангах зорилгоор “Гэрээт харуул, хамгаалалтын байгууллагын бүртгэлийн нэгдсэн сангийн SAS /security agency services/ програм” хангамжийг нэвтрүүлсэн бөгөөд гэрээт харуул, хамгаалалтын 467 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй (нийслэлд 390, орон нутагт 77)-гээс 399 аж ахуйн нэгж, байгууллага (нийслэлд 379, орон нутагт 20) буюу 85.5 хувь нь холбогдох санд холбогдох мэдээллээ санд шивж оруулсан.

*Гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээдийг хамгаалах чиглэлээр:* Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/75

дугаар тушаалаар Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн бүтэц орон тоонд өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний ил 4, маш нууцын зэрэглэлтэй 3, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 1, нийт 8 журмыг шинэчлэн боловсруулж, 2017 онд үйл ажиллагаанд холбогдон гарах зардлын төсөөллийг гаргаж холбогдох газарт хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд гэрч, хохирогчийг хамгаалалтад авхуулах тухай шүүгчийн захирамж 2, шүүхийн албан бичиг 2, прокурорын тогтоол 8, эрх бүхий албан тушаалтны шийдвэр 1, өмгөөлөгчийн хүсэлт 2, төрийн болон төрийн бус байгууллагын албан бичиг 3, иргэдийн өргөдөл 22, нийт 40 өргөдөл, гомдол, хүсэлт албан бичиг хүлээн авснаас 25-ыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч, урьдчилан сэргийлэх 19, биечилсэн 5, аюулгүй газарт түр байрлуулах 5, тусгай техник хэрэгслээр хангах 4 нийт 33 хэлбэрийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн, шүүгч 3, гэрч 4, хохирогч 23, хамаарал бүхий иргэн 12 нийт 42 иргэний аюулгүй байдлыг хангах ажиллыг зохион байгуулж, МҮОНТ-ийн 2 дугаар сувгаар гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн чиг үүргийн талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор нэвтрүүлэг бэлтгэж хүргэлээ.

*Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:* Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, гадаадын хууль сахиулах байгууллагатай харилцах, Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагатай хамтран ажиллах ажлын хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, айлчлал хийх, зохион байгуулах, мэндчилгээ дэвшүүлэх, судалгаа, мэдээлэл хүргүүлэх, мэдээлэл хүсэх, гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн талаар мэдээлэл солилцох зэрэг чиглэлээр нийт 15 улс орны дипломат төлөөлөгчийн газар, цагдаагийн байгууллага, олон улсын 7 байгууллагуудтай харилцаа, холбоотой ажиллаа. Тухайлбал:

ЦЕГ-ын даргаар ахлуулсан төлөөлөгчид 2016 оны 01 дүгээр сарын 18-24-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Итали Улсын Дотоод хэргийн яамны урилгаар айлчлал хийж, хоёр байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийн талаар, цаашид хамтран ажиллах боломж нөхцөл, үйл ажиллагааны чиглэлээр;

Канадын Хатан хааны морьт цагдаагийн газрын Бээжин дэх атташе Петер Квок Ён Цуй, Роберт Ринг нарыг 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч уулзан, АСЕМ-ийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран сургалт зохион байгуулах, хамтын ажиллагааг үргэлжлүүлэх чиглэлээр;

Бээжин хот дахь Бүгд Найрамдах Итали Улсын Батлан хамгаалахын атташе, бригадын генерал Фабиано Зинзоне /Fabiano Zinzone/-г өөрийх нь хүсэлтээр хүлээн авч уулзан, цаашдын хамтын ажиллагааны талаар;

ЦЕГ-ын урилгаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавари муж улсын Цагдаагийн газрын ерөнхийлөгч Вилхелм Шмидбауэр, Мюнхен хотын Цагдаагийн газрын ерөнхийлөгч Юбертус Андре нар 2016 оны 04 дүгээр сарын 19-нөөс 23-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлал хийж хамтран ажиллах санал тавьж, цаашдын хамтын ажиллагааны талаар;

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үеэр ажиглагчаар оролцох Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын Ардчилсан институт, хүний эрхийн газрын төлөөлөгчдийн тэргүүн, Элчин сайд хатагтай Одри Гловерийг өөрийнх нь хүсэлтийн дагуу хүлээн авч уулзаж сонгуулийн үйл явц, аюулгүй байдлын талаар;

БНСУ-ын Дээд Прокурорын газрын төлөөлөгчдийг Цагдаагийн ерөнхий газарт хүлээн авч уулзалт зохион байгуулж, 2017 оноос Монгол Улсад хэрэгжүүлж эхлэх хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх арга хэмжээний төслийн талаар;

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 05-наас 08-ны өдрүүдэд ОХУ-д хийсэн айлчлалын бүрэлдэхүүнд Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис орж ажилласан. Айлчлалын хугацаанд "Гэмт хэрэг, хууль бус цагаачлал" сэдэвт хоёр талын ажлын зөвлөлдөх уулзалтад оролцож, Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар болон Гадаадын иргэн, харьяатын газрын зүгээс ОХУ-ын ижил чиг үүрэг бүхий холбогдох байгууллагуудтай цаашид хамтран ажиллах хэтийн чиглэлүүдийн талаар;

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөрмонголын өөртөө засах орны Эрээн хотын НАХТовчооны дарга Бао Пейюй тэргүүтэй 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 2016 оны 08 дугаар сарын 01-нээс 05-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилж, Эрүүгийн цагдаагийн газар, Улаанбаатар хотын цагдаагийн газрын удирдлагуудтай уулзалт хийж хоёр талын терроризм, хар тамхи, эдийн засаг, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тус тус харилцан санал солилцов.

Гадаад харилцааны хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Г.Бадарч тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн урилгаар 2016 оны 03 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд айлчлал хийж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн дотоод хяналт аюулгүй байдал, гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл, нохой сургалтын болон холбогдох бусад албадын үйл ажиллагаатай танилцаж, 2016 онд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ, сургалтын талаар харилцан санал солилцсон бөгөөд айлчлалын үеэр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимээс Монгол Улсын цагдаагийн байгууллагад "Малино" үүлдрийн нохойн 2 гөлөг бэлэглэв.

ЦЕГ-ын урилгаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны НАХТ-ийн орлогч дарга, цагдаагийн генерал Чень Инзе тэргүүтэй 6 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 2016 оны 05 дугаар сарын 30-наас 5 хоногийн хугацаатай Монгол Улсад айлчлал хийж, Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Сургалтын төв , Налайх дүүрэг, Төв аймаг дахь цагдаагийн газрын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцлаа.

БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны цагдаагийн атташе Ким До Хан-тай уулзалт зохион байгуулж, БНСУ-ын КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр ажиллаж буй зөвлөх мэргэжилтний хугацааг 1 жилээр сунгав.

Америкийн Нэгдсэн Улсаас Загас болон зэрлэг ан амьтан хамгаалах алба /Fish and Wildlife/-ны Бээжин хот дахь атташе хатагтай Эштон Күү 2016 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Мөрдөн байцаах газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн удирдлагатай ажлын танилцах уулзалт зохион байгуулж, алба хаагчдыг суралцуулах, туршлага солилцох чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.

АНУ-ын Холбооны мөрдөн товчооны Бээжин хот дахь хуулийн атташе Триплетт Холден 2016 оны 08 дугаар сарын 18-ны өдөр ажлын уулзалт хийсэн ба "Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар болон Америкийн Нэгдсэн Улсын Холбооны мөрдөх товчоо хооронд эрүүгийн хэрэгт ашиглах болон терроризмыг таслан зогсоох зорилгоор эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад гарын сангийн нэгдсэн мэдээллийг талууд харилцан солилцох тухай хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн төслийг гардуулсан. Үүний дагуу "Санамж бичиг"-ийг байгуулах зорилгоор төслийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүллээ.

"Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/"-ын Үндэстэн дамнасан аюул заналхийлэлтэй тэмцэх албаны олон улсын шинжээч-мэргэжилтэн Хил гаалийн асуудал эрхэлсэн зөвлөх Горанчо Стожковски, Цагдаагийн

стратегийн асуудал эрхэлсэн газрын зөвлөх Жеральд Ньюхаус, Терроризмтэй тэмцэх газрын ажилтан Камилла Богное, Мехди Кнани нар 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны хилийн бүсийн хамтын ажиллагааны асуудлаарх хамтарсан ажлын хэсгийн хуралдааныг 2016 оны 09 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр нэгдсэн ойлголтод хүрч, шийдвэрлэх, хэрэгжүүлэх асуудлуудыг тодорхойлсон.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний цагдаагийн газрын сургагч багш нарыг урьж 2016 оны 09 дүгээр сарын 19-нөөс 30-ны өдрүүдэд “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх” нь сэдэвт сургалтыг алба хаагчдад зохион байгууллаа.

Цагдаагийн Ерөнхий Газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан (ХАС)-гийн хооронд байгуулах Монгол Улсыг НҮБ-аас 2017-2021 оны хугацаанд дэмжиж хэрэгжүүлэх дараагийн таван жилийн хөтөлбөртэй холбогдуулан НҮБ-ын ХАС-гийн санхүүжилттэй ажлын төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх ЦЕГ, НҮБ-ын Хүн Амын сангийн хамтарсан гэрээнд гарын үсэг зурах ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Япон Улсын Үндэсний цагдаагийн газрын Терроризмтой тэмцэх албаны тэргүүн дэд дарга, Олон улсын терроризмтой тэмцэх албаны ахлах зөвлөх, туслах комиссар Масафуми Кондо тэргүүтэй төлөөлөгчдийг 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авч Ази, номхон далайн бүс нутаг дахь терроризмын нөхцөл байдал, терроризмтой тэмцэх чиглэлээр хоёр орны цагдаагийн байгууллагын явуулж буй үйл ажиллагааны талаар харилцан танилцуулгаа хийж, цаашид мэдээлэл, туршлага солилцож хамтран ажиллах талаар санал солилцов.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн орлогч дарга Лян Шяопин тэргүүтэй төлөөлөгчид 2016 оны 11 дүгээр сарын 02-ноос 07-ны өдрүүдэд Монгол Улсын цагдаагийн байгууллагад ажлын айлчлал хийж цагдаагийн байгууллагад ХБНГУ-д үйлдвэрлэсэн Сантана маркийн автомашин 8 ширхгийг буцалтгүй тусламжаар бэлэглэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис, Интерполын Үндэсний төв товчооны ажлын албаны дарга, цагдаагийн хурандаа Г.Бадарч нар 2016 оны 11 дүгээр сарын 7-11-ний өдрүүдэд Индонези Улсын Денпасар хотноо зохион байгуулагдсан Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполын 85 дугаар Ерөнхий ассамблейн чуулганд оролцлоо.

Тайлангийн хугацаанд АНУ, БНХАУ, Япон, ХБНГУ, БНСУ, БНЭУ, БНПУ, АБНЕУ, Тайландын Нэгдсэн Вант Улс, Шинэ Зеланд зэрэг гадаад улс орнуудын ижил чиг үүрэг бүхий цагдаа, хууль сахиулах байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн сургалт, гадаад арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 219 алба хаагчийг ЦЕГ-ын удирдлагын шийдвэрийн дагуу хамруулсан. Үүнээс богино хугацааны 34 сургалтад 119 алба хаагч, айлчлал, туршлага судлах 24 арга хэмжээнд 65 алба хаагч, олон улсын хурал, семинар, тэмцээн, аялал зэрэг 12 арга хэмжээнд 45 алба хаагч оролцуулж арга хэмжээний явц, үр дүнг тооцон ажиллаа.

*Архивын үйл ажиллагааны чиглэлээр:* Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын газар нь 2016 онд явагдсан Төрийн архивын улсын үзлэгээр “А” буюу 99.5 үнэлгээтэй шалгагдаж, улсын хэмжээнд нэгдүгээр байр эзэлсэн.

Тус газар нь захиалгаар 1037, албан бичгээр 532, өргөдлөөр 32 нийт 1601 алба хаагч, иргэнд цагдаагийн байгууллагад ажилласан жилийн архивын лавлагаа, цалингийн тодорхойлолт, хугацаат цэргийн алба хаасан тухай архивын лавлагааг олгосон. Архивын лавлагаа хуулбар олгохоор архивчид нь тус газрын хадгаламжийн санд хадгалагдаж байгаа 7878 хадгаламжийн нэгж буюу 15448293 хуудас материал

болон 839 алба хаагчийн боловсон хүчний хувийн хэрэг Цагдаагийн ерөнхий газрын хүний нөөц сургалтын хэлтсээс 441 хувийн хэргийг түр хугацаагаар шилжүүлэн авч шүүлт хийж ажиллаа.

Архивын газрын хадгаламжийн санд хадгалагдаж байгаа баримтаас хуулбар авахаар хүсэлтээ ирүүлсэн 10 иргэний захиалга, 39 өргөдөл, 96 байгууллагын албан бичгийг хүлээн авч, нийт давхардсан тоогоор 183 хөмрөгийн 197 хадгаламжийн нэгжийн 29533 хуудас материалаас шүүлт хийж, 792 хуудас баримт бичгийг хуулбарлан баталгаажуулж үйлчилсэн. Нийт 1601 алба хаагч, иргэнд архивын лавлагаа, 792 хуудас баримт бичгийг хуулбарлан баталгаажуулж үйлчилсэн.

АЕГ-тай байгуулсан гэрээний дагуу 4 гэрээт-архивч операторыг томилон ажиллуулж, хадгаламжийн санд хадгалагдаж байгаа 81 хөмрөг үүсгэгч байгууллагуудын баримтаас цахим хэлбэрт оруулахаар 16 хөмрөг, 19 данс, 406 хадгаламжийн нэгжийн 71264 хуудас материалыг холболт хийж, Photoshop программаар 16 хөмрөгийн 18 дансны, 335 хадгаламжийн нэгжийн 67718 хуудас тушаалыг засварласан байна. Үүнээс AMS программд нийт 51 хөмрөгийн 52 дансны, 626 хадгаламжийн нэгжийн 105876 хуудас тушаалыг цахим хэлбэрт оруулжээ. Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт оруулж байгаа мэдээг АЕГ-ын мэдээлэл, үйлчилгээний удирдлагын газарт сар бүр өгч, удирдамж чиглэл авч ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх ББНШАЗК-ын хурлуудаас гарсан шийдвэрийг албажуулах ажлын хүрээнд болон газрын нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу хөмрөг үүсгэгч 40 байгууллагаас 2986 байнга хадгалах хадгаламжийн нэгж, 654 боловсон хүчний хувийн хэргээр нөхөн бүрдүүлэлт хийж, шинэчилсэн дугаар олгож санд байрлуулав.

ЦЕГ-ын дэргэдэх ББНШАЗК-ын 2016 оны 3 дугаар хуралд бэлтгэх ажлын хүрээнд 17 хөмрөг үүсгэгч байгууллагын байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, боловсон хүчний хувийн хэргийн бүртгэл, устгах хэргийн актыг хянаж шаардлага хангаагүй бүртгэлийг засварлан зөвлөмжийн хамт албан бичгээр буцаан хүргүүллээ.

Тусгай санд хадгалагдаж байгаа 1943-2015 оны 484 байнга хадгалах хадгаламжийн нэгжүүдийг 29 хөмрөг, 1960-2015 оны 3430, 60 жил хадгалах хадгаламжийн нэгжүүдийг 48 хөмрөгийг шинэчилсэн дугаар олгож, санд байрлуулсан. Тусгай санд хөмрөг үүсгэгч нийт 20 байгууллагаас байнга хадгалах 44 хадгаламжийн нэгж, 60 жил хадгалах 284 хадгаламжийн нэгжийг тус тус хүлээн авч бүртгэлжүүллээ.

Увс аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн нууцын зэрэглэлтэй баримт бичгийн “Устгах хэргийн акт” №01, №02, Завхан, Төв, Сэлэнгэ, Увс аймаг дахь цагдаагийн газрууд болон Цагдаагийн ерөнхий газрын Автобааз, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Мэдээлэл технологийн төв, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн нууцын зэрэглэлтэй байнга, 60 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлүүдийг нягтлан шалгаж, ЦЕГ-ын дэргэдэх НББНШАЗК-ын 03 хурлаар хянан хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

*Судлагаа, дүн шинжилгээний ажлын талаар:* АСЕМ-ын чуулга уулзалттай холбогдуулан “Биеэ үнэлэхийг зохион байгуулах, биеэ үнэлэх гэмт хэрэг зөрчил”, “АСЕМ-тай давхцах баяр арга хэмжээ”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах”, “Сонгуулийн болон Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг, зөрчил”, “АСЕМ-ийн чуулга, уулзалтын үеэр анхаарах зарим асуудал”, “Цагдаагийн байгууллага болон алба хаагч, тэдний үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээлэл, интернет, цахим орчинд гарч байгаа мэдээ, сэтгэгдэл”, “Цагдаагийн байгууллагын хэмжээнд үйлчилж буй мэдээлэл, тоо бүртгэлийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж нь Монгол Улсын бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэх”, “Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эрэг гэмт хэргийн нөхцөл байдал”, “Дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Цагдаагийн байгууллагын хөгжлийн

стратеги хөтөлбөр”, “Гэмт хэргийг илрүүлж, эзэн холбогдогчийг олж тогтооход дүн шинжилгээний дэвшилтэт, хамгийн үр дүнтэй, орчин үеийн арга болох “Criminal profiling аргачлалын тухай”, “Зам тээврийн осол, хэргийн шалтгааныг тогтоох, дүгнэлт гаргах 3D төхөөрөмж”, “Гэмт явдалтай тэмцэж буй гадаад орнуудын туршлагын талаар нээлттэй эх сурвалж болох цахим ертөнцийн хүрээнд судлан Их Британи Улсын цагдаагийн байгууллагын “Track my crime” цахим үйлчилгээний тухай”, “Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар”, “Хамгаалалтын програм хангамжийн ашиглалт, баяжилт, хөдөлгөөнийг сайжруулах талаар”, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Хууль сахиулах ажиллагааны тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын төслүүдийн үзэл баримтлалтай танилцаж “Эрүү, Зөрчлийн материаллаг хуулиуд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын төслийн шинэлэг эрх зүйн зохицуулалтын онцлог, цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд бий болох хууль зүйн үр дагаврын төсөөлөл, таамаглал”, “Эрүүгийн материаллаг, процессын хуулиуд батлагдсантай холбогдуулан цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх ажлын бүтэц зохион байгуулалтад орох төсөөлөл”, “Эдгээр батлагдах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад цагдаагийн байгууллагад бий болох тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам”-ын талаар гэх мэт нийт 69 асуудалд судалгаа, дүн шинжилгээ хийн, танилцуулга бичиж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын санал, зөвлөмж, үүрэг чиглэлийг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2015 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн зарим тодорхой төрлийн гэмт хэргийн статистик тоон харьцуулалтыг 6, 10 жилийн байдлаар бэлтгэн гаргасан бөгөөд Мэдээлэл, технологи, холбооны газраас жил бүр эмхлэн гаргадаг “Монгол Улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал-2015” товхимолд оруулж мэдээлсэн.

“Бостоны террорист халдлага”, “Өнгөлөг Албани”, “Удирдах ур чадвар”, “Гэмт хэрэгтэй тэмцэхэд статистик мэдээллийн сангийн ач холбогдол” гэсэн 4 төрлийн видео бичлэгийг DVD болгон албаны хэрэгцээнд ашиглаж байгаа бөгөөд

2016 оны 05 дугаар сарын 06-аас эхэлж цагдаагийн холбогдох алба, нэгжээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчил, сонгуулийн талаарх мэдээ, мэдээлэлд үндэслэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, Хууль зүйн яаманд нийт 55 мэдээ мэдээлэл, танилцуулга, албан бичгийг боловсруулж хүргүүлсэн.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга болон Хууль зүй, дотоод хэргийн сайдад 7 хоног бүрийн эрүү болон хэв журмын нөхцөл байдлын талаарх 25 удаагийн 41 танилцуулга, мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн бөгөөд энэхүү танилцуулга мэдээллийг 12 сараас эхлэн “Info Graph” хэлбэрээр хүргүүлдэг болов.

Авлигатай тэмцэх газраас санал авч “Цагдаагийн байгууллагын бүтэц, албан тушаалын нэршилд өөрчлөлт орсонтой холбогдуулан авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаалыг тодорхойлох” судалгааны ажлыг боловсруулсан.

Цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаа програм, техник хангамж, системийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээл, эрсдэлийн талаарх санал асуулгыг алба хаагчдаас авч нэгтгэн холбогдох байгууллагуудад танилцуулахаар бэлтгэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүргийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагааг дэмжих, судалгааны ажлыг чанаржуулах зорилготой судалгааны багт 2 алба хаагч хамтран ажиллалаа.

*Сургалтын чиглэлээр:* Хууль сахиулах салбарын бодлого, чиглэл, Цагдаагийн байгууллагаас 2016 онд дэвшүүлсэн зорилт, цагдаагийн байгууллагын 2015 оны албаны сургалтын үр дүн, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагаас ирүүлсэн санал, сүүлийн 3 жилийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, цагдаагийн алба хаагчдын боловсрол, мэргэжил, гаргаж буй сахилга, ёс зүйн зөрчил, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар хийсэн судалгаа зэрэгт дүн шинжилгээ хийж, тэдгээрт үндэслэн "Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2016 оны сургалтын төлөвлөгөө"-г боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/106 дугаар тушаалаар батлуулан, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаа.

Сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газар, Улсын прокурорын ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн, Эрүүл мэндийн үндэсний хүрээлэн, Эмгэг судлалын үндэсний хүрээлэн, Хууль сахиулахын их сургууль, Монгол Улсын их сургууль, Багшийн их сургууль, Боловсролын хүрээлэн, Хүний нөөцийн институт, "Цэргийн нөхөрлөл" төрийн бус байгууллага, Цагдаагийн байгууллагын ахмадын холбоо зэрэг сургалтын мэргэшсэн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллав.

Энэ онд төлөвлөгөөт болон захиалгат нийт 137 сургалт зохион байгуулж, 7223 алба хаагч, 726 иргэн хамрагдсан байна. Үүнээс:

*а/ Төлөвлөгөөт сургалт:*Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/106 дугаар тушаалаар батлагдсан "Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2016 оны сургалтын төлөвлөгөө"-ний дагуу дараах сургалтуудыг зохион байгуулж, сургалтын явц байдалд хяналт тавьж ажиллаа.

Сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 115 удаагийн сургалт зохион байгуулагдахаас 95 сургалт явагдаж, гүйцэтгэл 82.6 хувьтай байна. Монгол Улсад зохион байгуулагдсан "Ази-Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт", Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгууль болон төсөв, хөрөнгийн байдлаас шалтгаалан зарим сургалтуудыг хойшлогдсон.

Удирдлагын чиглэлээр нийт 6 удаагийн 144 цагийн сургалтад 180 удирдах ажилтан, Гэмт хэрэгтэй тэмцэх албаны чиглэлээр нийт 21 удаагийн 520 цагийн сургалтад 630, Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр нийт 19 удаагийн 456 цагийн сургалтад 570, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиглэлээр нийт 12 удаагийн 288 цагийн сургалтад 360 алба хаагч, Ахисан шатны ур чадвар ахиулах чиглэлээр нийт 22 удаагийн 758 цагийн сургалтад 450 алба хаагч тус тус хамрагдсан.

*б/ Захиалгат /төлөвлөгөөт бус/ сургалт:*Тус төвд Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Хууль сахиулах салбарын бодлого, чиглэл, удирдлагаас өгсөн үүргийн дагуу захиалга /төлөвлөгөөт бус/-аар цагдаагийн алба хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр "Мэргэшсэн хэрэг бүртгэгч-1,2,3,4", "Хэргийн газрын үзлэг-прокурор", "Хэргийн газрын үзлэг-тээврийн прокурор", "Хэргийн газрын үзлэг-мөрдөн байцаагч-1,2", "Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн алба хаагчдыг мэргэшүүлэх", "9мм-ПМ гар буу эзэмших", "Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдыг бэлтгэх, НҮБ-ын стандарт сургалт", "Олон Улсын шинж чанартай арга хэмжээнүүдийн төлөвлөлт, зохион байгуулалтын арга, тактик", "Нийтийг хамарсан арга хэмжээний үед ажиллах арга тактик" зэрэг модулийн сургалтыг зохион байгуулж, нийт 4133 алба хаагчдыг, "Олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх" 3 удаагийн сургалтад 96 иргэн, иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны 12 удаагийн сургалтад 630 иргэн, нийт 726 иргэнийг;

"Гал голомт" Үндэсний хөдөлгөөнөөс "Жендер, хүний эрх, хувийн нууц" сэдэвт сургалтыг хамтран зохион байгуулах хүсэлтийн дагуу сургалтад хамрагдах харьяа

дүүргийн цагдаагийн хэлтсийн хэв журмын тасгийн дарга нарын нэрсийг гарган 2016 оны 03 дугаар сарын 16-17-ны өдөр сургалтад;

Санамж бичгийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнд 2016 оны 02 дугаар сарын 25-26-ны өдөр зохион байгуулагдсан "Хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх" сургалтад хамрагдах хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын нэрсийг харьяа дүүргийн цагдаагийн хэлтсүүдээс албан тоотоор авч нийт 32 хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарыг 2 өдрийн сургалтад тус тус хамруулав.

Хүний Эрхийн Үндэсний комисстой хамтран ХСИС-ийг 2016 оны төгссөн 177 алба хаагчид "Ажлын чиг баримжаа олгох" модулийн сургалтыг 2016.06.06-08-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтын хөтөлбөрийн дагуу "Хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах" сэдвээр Хүний Эрхийн Үндэсний комиссын гишүүнийг урьж сургалт явуулсан.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны болон алба хаагчдын "Хүний эрхийг хангахад цагдаагийн байгууллагын оролцоо" сэдэвт ур чадвар ахиулах ахисан шатны модулийн сургалтуудыг 2016 оны 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулж 20 алба хаагчийг хамруулаа.

Хээрийн сургалтад нийт 14 ээлжээр 3977 алба хаагч хамрагдахаас 3776 алба хаагч буюу 95 хувь нь хамрагдаж "Цагдаа ба хүний эрх", "Олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа", "Албаны бэлтгэлжилт", "Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх чадвар", "Харилцааны ёс зүй, сэтгэл зүйн бэлтгэл" зэрэг сэдвүүдийн хүрээнд 348 цагийн хичээл зааж, сэтгэл зүйн 3140, цагдаа ба хүний эрх 2030, эмнэлгийн анхан шатны тусламж 1190, холбооны бэлтгэл 610 нийт 4 хичээлийн 6970 ширхэг "Зөвлөмж" гарын авлагын эх боловсруулан тараасан байна.

Ханнс-Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр ХБНГУ-ын Бавари муж улсын Аугсбургын Эрүүгийн цагдаагийн газраас зохион байгуулах "Кибер гэмт хэрэгтэй тэмцэх" чиглэлийн сургалтыг 2016 оны 10 дугаар сарын 03-ний өдрөөс мөн сарын 05-ны өдрүүдэд Эрүүгийн цагдаагийн газрын хурлын танхимд зохион байгуулж, кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа 51 алба хаагчийг хамруулаа.

Цагдаагийн байгууллага анх удаа дотооддоо удам угшал сайтай албаны нохойн нөхөн хангалтыг бэлтгэх ажлыг эхлүүлж, үржлийн Герман овчарка үүлдрийн эр, эм нохдыг зохих шалгуурын дагуу сонгон авч, үржүүлэн стандарт шаардлагад нийцсэн нохойг бэлтгэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан бөгөөд энэ ажлын хүрээнд 5 нохойг хүлээн авч, өсгөн бойжуулж, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулж байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч нохой, харуул, хамгаалалтын нохой, бусад хууль сахиулах байгууллагуудын албаны нохойг сургаж бэлтгэх ажлыг төлөвлөн, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Улсын хэмжээнд нохойн төлөөлөгч нар 1764 удаа, 35276 цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгэж, гэмт хэрэг, зөрчлийн дуудлагад 2030 удаа очиж, албаны нохойг 739 удаа ашиглан, 157 сая 785 мянган төгрөгийн хохиролтой, 171 холбогдогчтой, 151 гэмт хэргийг илрүүлсэн байна.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойд зориулан "АБСОЛЮТ" сургалтын төвийн дэмжлэгтэйгээр гадаад хэлний танхимыг тохижуулан алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион явуулж байна.

*Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:* Цагдаагийн байгууллагын "Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөө"-г боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулж, 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 4/197 дугаар албан бичгээр төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаа.

Цагдаагийн байгууллагын 4397 алба хаагчийн 2015 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авах ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, шинээр болон дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 95 алба хаагчийн урьдчилсан мэдүүлэг, холбогдох материалыг санд оруулж, Авлигатай тэмцэх газраар дүгнэлт гаргуулав.

Мөн шинээр, ахлагч бүрэлдэхүүнээс офицер албан тушаалд дэвшин томилогдсон 883 алба хаагчийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг, Тахарын ерөнхий газар татан буугдсантай холбоотойгоор цагдаагийн байгууллагад шилжин ирсэн 72 алба хаагчийн ХАСХОМ-ыг албан тушаал, ажлын байр нэг бүрийг зохих нэршлийн дагуу цахим санд бүртгэсэн.

Цагдаагийн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Цагдаагийн байгууллагад биеэр хандаж ирсэн иргэнийг угтан авч, зөв боловсон харьцаж, санал хүсэлтийг нь хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх, зөвлөгөө өгөх үүрэг бүхий угтагч цагдааг сургаж дадлагажуулах” ажлыг зохион байгууллаа.

Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, Авлигатай тэмцэх газартай хамтран сургагч багшаар бэлтгэгдсэн алба хаагчдыг давтан болон мэргэшүүлэх сургалтыг бүсчилсэн хэлбэрээр явуулахаар төлөвлөж эхний ээлжид Дорноговь аймгийн Сайншанд суманд энэ оны 03 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд 20 алба хаагч, нутаг дэвсгэрийн захиргааны байгууллагын 15 ажилтныг хамруулав.

Цагдаагийн ерөнхий газрын төв байрны алба хаагчдын дунд зохион байгуулах, 2016-2017 оны сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд заагдсаны дагуу 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн алба хаагчидтай хамтран “Монгол Улсын авлигын нөхцөл байдал” сэдвээр, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас 2016 оны 11 дүгээр сарын 07-11-ний хооронд зохион байгуулагдсан “Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын ёс зүй ба авлигатай тэмцэх” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, холбогдох мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын police.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

Авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаалыг тодорхойлох зорилгоор Авлигатай тэмцэх газартай хамтран 2016 оны 10 дугаар сарын 09-21-ний өдрүүдэд Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь, Төв аймаг дахь цагдаагийн газар, Улаанбаатар хотын цагдаагийн газрын Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн алба хаагчдын дунд ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага зохион байгуулж, 1123 иргэнээс асуулгын хуудсаар санал авч, дүнг нэгтгэн танилцууллаа.

*Хэвлэл мэдээллийн чиглэлээр:* Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810 жил, Ардын хувьсгалын 95 жилийн ойн Үндэсний их баяр наадмын үеэр цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн ажлын талаар 36, АСЕМ-ийн уулзалтын үеийн хэв журмын хамгаалалтын талаар 18, Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 25, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Могойн голыг бохирдуулсан, хууль бус үйл ажиллагаа явуулсан хэргийг илрүүлэн шалгаж байгаа талаар 20, Картын залилангийн гэмт хэргийн талаар 27, Монгол Улсад амь насаа алдсан Англи Улсын иргэний талаар 24, Дорнод аймгийн Хэрлэн суманд 7 настай Т нь гадны нөлөөтэй нас барсан гэмт хэргийг илрүүлэн шалгаж байгаа талаар 30, нийт 762 хэвлэл, мэдээллийн байгууллагад 28 удаа мэдээ, мэдээлэл өгч ажиллаа.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор МҮОНТ-ийн нэгдүгээр сувгаар 7 хоног бүрийн баасан гаргийн 18:35 цагаас 15 минутын “Цагдаагийн мэдээлэл”, МҮОНТ-ийн 2-р суваг телевизээр 7 хоног бүрийн

Пүрэв гарагийн 18.30 цагаас 30 минутын “Амрыг эрье” нэвтрүүлгийн 96 дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зууны мэдээ, Өнөөдөр, Монголын үнэн, Өглөөний сонин зэрэг өдөр тутмын сонинд 260, Shuud.mn, Medee.mn, 24 tsag.mn, Zaluu.com, Itoim.mn, Ikon.mn, Dorgio.mn зэрэг мэдээллийн сайтад 545, МҮОНР-д 95, телевизэд 620, нийт 1520 ярилцлага өгч ажилласан байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд болж өнгөрсөн онцлох үйл явдлуудыг тоймлон, улирал бүр алба хаагчдад хүргэдэг “Цагдаа" эмхэтгэл” сэтгүүл 3000 ширхгийг хэвлүүлэн хуваарийн дагуу төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэв.

Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн хэрэгжилт, Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 134.4.2, 134.10.4-ын заалтыг хангаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас www.police.gov.mn/, www.facebook.com, www.twitter.com, www.youtube.com/ цахим хуудас ажиллуулж “Нүүр”, “Бидний тухай мэдээлэл”, “Хууль эрх зүй”, “Тусгай зөвшөөрөл”, “Иргэний хяналт”, “Олон нийтийн цагдаа”, “Мэдээллийн ил тод байдал”, “Эхлэл”, “Байгууллага”, “Мэдээлэл”, “Зөвшөөрөл”, “Иргэний зөвлөл”, “Шилэн данс” гэсэн ерөнхий цэс, дэд цэсүүдэд нийт 285 мэдээ, мэдээлэл нийтлэн, өдөр бүр дэд цэснүүдийн агуулгын хүрээнд баяжуулж, холбогдох зураг, статистик тоо баримтыг хавсарган байршуулсан.

Мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 25 видео бичлэг, 75 зурагт хуудсыг өөрийн фэйсбүүк, юутүүб, твиттер хуудсанд байршуулсныг давхардсан тоогоор олон нийтийн сүлжээ хуудас /facebook, twitter, youtube/-нд байршуулсныг давхардсан тоогоор 4.0 сая гаруй хэрэглэгч үзсэн байна.

*Дөрөв. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний ажлын талаар:*

Цагдаагийн ерөнхий газар нь 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 141.2 тэрбум төгрөгийн төвлөрсөн санхүүжилт, 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлого болох гэрээт, эрүүлжүүлэх, баривчлах, журмын хашаа, хэвлэхийн орлогоор 8.7 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалаас олгох санхүүжилтээр 121.0 сая төгрөгийн орлого оруулаа.

Төсвийн зарлагын санхүүжилтийн хуваарийн дагуу 2016 онд “Урсгал зардал”-д нийт 151.2 тэрбум төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 150.0 тэрбум төгрөг зарцуулж 1.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй буюу 99 хувийн гүйцэтгэлтэй ажиллав.

“Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал”-д нийт 107.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 107.0 тэрбум төгрөгийг зарцуулж 454.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 99 хувийн гүйцэтгэлтэй, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт 3.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 2.9 тэрбум төгрөгийг зарцуулж 162.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 95 хувийн тус тус гүйцэтгэлтэй гарсан байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд нийт 4.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 4.1 тэрбум төгрөг, хангамж бараа материалын зардалд 6.6 тэрбум төгрөг батлагдсанаас 6.5 тэрбум төгрөг, норматив зардалд 6.6 тэрбум мянган төгрөг батлагдсанаас 6.4 тэрбум төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2.4 тэрбум төгрөг батлагдсанаас 2.2 тэрбум төгрөг, томилолт, зочны зардалд 672,5 сая төгрөг батлагдсанаас 645.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардалд 11.9 тэрбум төгрөг батлагдсанаас 11.9 тэрбум төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 445.9 сая төгрөг батлагдсанаас 437.2 сая төгрөг, ЗГ-ын шилжүүлэг 39.3 сая төгрөг зарцуулахаас 37.2 сая төгрөг, нэг удаагийн буцалтгүй

тусламж шилжүүлгийн зардалд 7.3 тэрбум төгрөг батлагдсанаас 7.8 тэрбум төгрөгийг тус тус зарцууллаа.

Цагдаагийн байгууллагын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас шалгалт хийж, 27 байгууллага хамрагдан, санхүүгийн тайланг баталгаажуулахад аудитаар шалгагдсан 27 байгууллага "Зөрчилгүй", 1 байгууллага хязгаарлалттай санал дүгнэлт гарсан байна.

2015 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, 2016 оны 1-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээг Цагдаагийн ерөнхий газрын www.police.gov.mn сайтын шилэн дансны мэдээлэл хэсэгт байршуулав.

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2016 оны худалдан авах төлөвлөгөөг гаргаж шатахуун, нүүрс, компьютерийн тендерүүдийн урилга бусад мэдээллийг www.e-procurement.mn, www.police.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулж, 2015 оны худалдан авалтын тайлан, 2015 оны 12 сарын болон 2016 онд 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтыг нийтэд ил тод мэдээлж тайланг зохих хугацаанд гаргаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Улсын төсвийн 4.6 тэрбум төгрөгөөр дүрэмт хувцас, хэрэглэл бэлтгэх төсөв батлагдаж, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 122, 2013 оны 309 дүгээр тогтоол, Хууль зүйн сайдын 2015 оны А/275, 2016 оны А/07 дугаар тушаал, 2016 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/613 дугаар тушаалаар цагдаагийн алба хаагчдад 4,3 тэрбум төгрөгөөр 37 нэр төрлийн дүрэмт хувцас, хэрэглэл, 8 нэр төрлийн дүрэмт хувцасны үндсэн болон туслах материал бэлтгэн нийлүүлэх нээлттэй шалгаруулалтын ажлыг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийг томилж, гэрээ ёсоор бараа бүтээгдэхүүнийг бүрэн хүлээн авав.

Улаанбаатар цагдаагийн хүрээний байгууллагын хэрэгцээнд шатахуун, тослох материал бэлтгэн нийлүүлэгчийг нээлттэй тендерээр сонгон шалгаруулж, тендерийн үнэлгээний хорооны шийдвэрээр "Петростар" ХХК-ийг 1 дүгээр багцад 1.521.301.040, 2 дугаар багцад 1.636.861.660 төгрөгөөр шатахуун нийлүүлэгчээр, "Сод Монгол Групп" ХХК-ийг 3 дугаар багцад 52.692.500 төгрөгөөр тослох материал нийлүүлэгчээр тус тус шалгаруулж гэрээний дагуу бараа бүтээгдэхүүнийг бүрэн нийлүүлж дууслаа.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/125 дугаар захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооноос зарласан Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтсийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Тэд констракшн" ХХК шалгаран, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай гэрээ байгуулж, орон нутгийн төсвөөс батлагдсан 900.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд барилгын ажлыг энэ оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлсэн боловч батлагдсан санхүүжилт дуусаны улмаас барилгын ажил 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс түр зогсоод байна.

АСЕМ-ийн 11 дүгээр уулзалтын хамгаалалтын үед ажилласан Шуурхай удирдлагын штабын тоног төхөөрөмжийн зардалд 17.2 сая төгрөг, зочид төлөөлөгчдийн хамгаалалтад ажиллах 52 машины суудлын бүрээс, номер, гэрчилгээ, даатгалын зардалд нийт 19.7 сая төгрөг, хамгаалалтын үед ажиллах алба хаагчдын нэгдсэн сургалт, хоол, шатахууны зардалд 29.1 сая төгрөгийг 38 цагдаагийн газар, хэлтсийн 2195 алба хаагч нарт олголоо.

АСЕМ-ийн хуралд зориулан ирсэн Цагдаагийн зориулалттай 52 ширхэг приус 30 автомашиныг хүлээлцсэн баримт, Засгийн газрын тогтоол, бэлтгэн нийлүүлсэн гэрээ материалыг бэлтгэн Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд явуулж зохих зөвшөөрөл тушаал шийдвэрийг гаргуулан, орлогод авч, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хуваарилан өгөв.

Улсын төсвийн 2016 оны хөрөнгө оруулалтаар орон нутгийн хэсгийн төлөөлөгчдийг ажлын байраар хангах ажлын хүрээнд 1.7 тэрбум төгрөг тусгагдсан

бөгөөд уг хөрөнгөөр нэг бүр нь 80 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 144м2 талбайтай албаны 2 өрөө, алба хаагчид амьдрах 2 өрөө бүхий 2 орон сууц, автомашины граж бүхий барилгыг 12 аймгийн 21 суманд барьж ашиглалтад оруулсан.

Үүнд: Архангай аймгийн Булган, Жаргалант сум, Баянхонгор аймгийн Шаргалжуут, Жинст сум, Булган аймгийн Баяннуур, Бугат сум, Орхон аймгийн Жаргалант сум, Дундговь аймгийн Луус, Гурвансайхан сум, Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Бат-Өлзий сум, Төв аймгийн Баян-Өнжүүл, Дэлгэрхаан сум, Увс аймгийн Хар тэрмис баг, Ховд аймгийн Манхан сум, Говь-Алтай аймгийн Хөх морьт, Тайшир сум, Дорноговь аймгийн Сайхан дулаан сум, Хөвсгөл аймгийн Цагаан-үүр сум, Алаг-Эрдэнэ сумын кобаны барилга бүрэн дуусч, ашиглалтад орсон бөгөөд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын “Ханги” боомт дахь кобаны барилгын ажлын гүйцэтгэл 90.0 хувьтай байна.

Цагдаагийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2016 онд цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 171 алба хаагчид 4 тэрбум 19 сая төгрөгийн тэтгэмж, Цагдаагийн албаны тухай хуулийн 37.2 зүйлд заасны дагуу аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа 83 алба хаагчдад 1,074,305.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг бодож тус тус олголоо.

Тахарын ерөнхий газар татан буугдсантай холбогдуулан 29,6 сая төгрөгийн өглөгийг 70 аж ахуй нэгж, байгууллагад төлж барагдуулан, Дорноговь, Өвөрхангай, Говь-Алтай, Орхон аймагт баригдаж цагдаагийн кобаны санхүүжилтэд 268.9 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид, Баянхонгор аймгийн цагдаагийн хэлтсийн барилга угсралтын явцад захиалагчийн хяналт хийсэн зардалд 10,4 сая төгрөг тус тус шилжүүлэв.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн нийт 6062 алба хаагчийг 115,3 сая төгрөгөөр “МИГ даатгал” ХХК-ий гэнэтийн ослын даатгалд, 111 барилга байгууламжийг 47,6 сая төгрөгөөр үл хөдлөх хөрөнгийн даатгалд, 319 техник хэрэгслийг 26,4 сая төгрөгөөр жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд /Ард даатгал ХХК/, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдыг Монголын элэгний эмч нарын нийгэмлэг, Элэгний төв, Оном сантай хамтран элэгний хатуурал, хорт хавдрыг үүсгэгч элэгний вирусийн халдварыг эрт илрүүлэх, уг өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмчилгээнд хамруулах зорилгоор үнэ төлбөргүй вакцинд 2077 алба хаагчийг тус тус хамруулаа.

Цагдаагийн ерөнхий газар Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран 2016 оны 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 12-ны өдрүүдэд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад бэлтгэх 14 өдрийн 116 цагийн хичээл сургалтыг зохион байгуулав.

Сургалтад Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа газрын 15, Улаанбаатар хотын Цагдаагийн газар болон дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн 10, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 5, хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагаас 2 нийт 32 санхүүгийн ажилтан хамрагдан “Санхүүгийн тайлан гаргах арга зүйн цогц бодлого”, “Мэдээллийн технологи, ур чадвар”, “Ёс зүй, мэргэжлийн үнэ цэнэ” хичээлүүдийн сорил шалгалт өгч, “Батламж” гардан авсан.

Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд худалдан авах ажиллагаанд оролцох эрх бүхий албан тушаалтнуудын дунд төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран худалдан авах ажиллагааны 3 өдрийн сургалтыг зохион байгуулж, сургалтад амжилттай оролцсон албаны дарга-2, газрын дарга-1, хэлтсийн дарга-15, ахлах мэргэжилтэн-14, нийт 32 цагдаагийн алба хаагч нарт худалдан авах тендерт оролцох эрх бүхий 3 жилийн мэргэжлийн үнэмлэх олгов.

Төв, орон нутгийн 65 цагдаагийн газар, хэлтсийн 9232 алба хаагчид нэгдсэн хангалтыг, 57 байгууллагын 2138 алба хаагч нарт баримтлан хангалтыг хийж, 49

байгууллагын 197 алба хаагчдад захиалгын хуудас олгож, нийт 48 нэр төрлийн 91444 ширхэг цагдаагийн дүрэмт хувцас, чимэг хэрэглэлийн хангалтыг хийсэн байна.

Мөн давхардсан тоогоор 326 төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд 992 нэр төрлийн 72,9 сая төгрөгийн хэвлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, захиалагч байгууллагуудад хүлээлгэн өгч ажиллаа.

Автобаазын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 287, Улаанбаатар хотын цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 238, нийт 525 автомашинаар цагдаагийн байгууллагын харьяа газар, хэлтэс нэгжүүдэд эргүүл, жижүүр, эрүүлжүүлэх, шуурхай ажил, хөдөө ажил, тээвэр үйлчилгээ, тусгай зориулалт, аж ахуй гэсэн 8 чиглэлээр чиг үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэн давхардсан тоогоор 68,209 удаа, 3,928,875 километр замыг туулсан байна.

Зам тээврийн осол, зөрчилд нийт 50 автомашин холбогдсоноос цагдаагийн байгууллагын алба хаагчдын буруутай 14, үлдсэн 36 осол нь гадны жолоочийн буруутай үйл ажиллагаанаас болжээ.

Зам тээврийн осолд холбогдсон 50 автомашины хохирлыг “Ард даатгал” болон буруутай жолоочоор нийт 60,0 сая төгрөгийн хохирлыг бүрэн барагдуулж, техникийн байнгын комисс шалгаж, үүрэг гүйцэтгэх нөхцөлийг бүрэн хангуулсан.

Цагдаагийн алба хаагчдын “Сүүж-Уул” сэргээн засах сувилалд цагдаагийн алба хаагч 200, ар гэр 441, цагдаагийн ахмад ажилтан 171, энгийн 345, урилгаар 62 нийт 1157 сувилуулагчдыг хүлээн авч, зохих эмчилгээ сувилгаанд хамруулав.

<u>Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойг угтаж дараах ажил, арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.</u> Тухайлбал;

Завхан аймаг дахь цагдаагийн газраас санаачлан цагдаагийн алба, ажилтны үйл ажиллагааг сурталчлах, хэсгийн төлөөлөгч нарын ажил мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг ахиулах, харилцан туршлага солилцох зорилгоор “Баруун бүсийн шилдэг хэсгийн төлөөлөгч-2016” цогцолбор тэмцээнийг Улиастай хотод энэ оны 04 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд, Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газрын санаачилгаар Замын цагдаагийн газартай хамтран “Баруун бүсийн уран зохицуулагч-2016” уралдаан, сургалт-зөвлөгөөнийг энэ оны 03 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд тус тус зохион явуулав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/164 дүгээр тушаалаар “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги, түүнийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага” сэдэвт онол, практикийн бага хурлыг 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хотын цагдаагийн газрын хурлын танхимд зохион байгуулсан бөгөөд нийт 80 алба хаагч оролцсон.

Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас “Байгууллага, алба хаагчдын соёлыг дээшлүүлэх нь” сэдэвт 2 сарын, Замын цагдаагийн газраас “Хөдөлгөөний соёл-Бидний оролцоо” уриан дор “Осолгүй жолооч-Жаргалтай гэр бүл” сэдэвт аяныг удирдамжийн дагуу зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын энэ оны 44 дүгээр тушаалаар батлагдсан “Тэргүүний Цэрэгжилч байдал, дүрэмч ажиллагаатай байгууллага шалгаруулах” тэмцээний удирдамжийн дагуу 2 үе шаттай зохион байгуулж, шалгаруулав.

Цагдаагийн байгууллагын түүхэн замнал, үйл ажиллагаа, алба хаагчдыг сурталчлан таниулах зорилгоор “ЦАГДАА-ФОТО ДУРАНД” гэрэл зургийн уралдаан зохион байгуулж, ирсэн бүтээлээр үзэсгэлэн гаргаж иргэд, олон нийтэд сурталчилсан. Гэрэл зургийг <u>policephoto2016@gmail.com</u> цахим шуудангаар хүлээн авч мэргэжлийн 10 гэрэл зурагчны 79, гэрэл зураг сонирхогчдын 279, нийт 358 гэрэл зураг ирүүлсэн.

Ойн арга хэмжээг угтан Хэвлэл мэдээллийн төвөөс “Монгол төрийн цагдаа-95” баримтат киноны найруулга, зураг авалтын хуваарийг гарган, цагдаагийн байгууллагаас төрөн гарсан 18 ахмад ажилтнаас ярилцлага авч, 19 цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагаа, хийгдэж буй онцлог ажлын талаар сурвалжилга, албадын дарга нараас ярилцлага авч үйл ажиллагаандаа ашиглав.

МҮОНТ-ийн “Дуудлага” нэвтрүүлгээр 19 цагдаагийн газар, хэлтэс, албадын баримтат сурвалжилга, нэвтрүүлгийг бэлтгэн, мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, түүхэн замналыг сурталчлах, иргэдийн санал, бодлыг сонсох зорилгоор www.police.gov.mn болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын цахим хуудаст “Цагдаа-95” тусгай булан нээж, үйл ажиллагаагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны төв, Хэвлэл мэдээллийн төв хамтран цагдаагийн байгууллагын бэлгэдэл “Цагаан шонхор”-ыг бүтээсэн, албаны бэлгэдэл болгон баталгаажуулсан эрхэм алдартнуудад хүндэтгэл үзүүлэх “Цагаан шонхор”-ыг мандуулах хүндэтгэлийн арга хэмжээг Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны төвд энэ оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулав.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, цагдаагийн мэргэжлийн албадын үйлчилгээг иргэд, олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриан дор 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Чингисийн талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж, 3000 орчим иргэд оролцуулсан байна.

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн барилгыг иж бүрэн засварлах ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын барилгын ажлыг “Хаш гоёо” ХХК-иар гүйцэтгүүлэн хүлээн авав.

Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын газрын дарга, бригадын генерал Т.Хүрэлбаатар, бригадын генерал А.Дулаанжаргал, судлаач Г.Отгонбаатар нарын эмхэтгэсэн “Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхэтгэл” нэртэй өнгөт 494 хуудас бүхий 500 ширхэг номыг хэвлүүлэн, олны хүртээл болгов.

Цагдаагийн байгууллагын түүхт 95, Улаанбаатар хотын цагдаагийн газрын 90, Цагдаагийн байгууллагын ахмадын холбооны 50 жилийг ойг угтаж Улаанбаатар хотын цагдаагийн газраас санаачлан цагдаагийн байгууллагын үе үеийн ажил мэргэжлийн болон хөдөлмөрийн аварга, ахмад ажилтнуудын ажлын тэргүүн туршлага, бүтээлч санаа, ажил үйлсийг хойч үедээ түгээн дэлгэрүүлэх, судлуулах, сурталчлах зорилгоор “Бидний бахархал” хүндэтгэлийн арга хэмжээг энэ оны 05 дугаар сарын 20-ны өдөр “Монголын хүүхдийн ордон”-ы бага танхимд зохион байгуулж 18 хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа.

Ойн арга хэмжээний хүрээнд цагдаагийн алба хаагчдын авьяас чадварыг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлах, баярын нэгдсэн тоглолтыг зохион байгуулах зорилготойгоор Улаанбаатар цагдаагийн хүрээний 24, орон нутгийн 18 газар, хэлтсийн алба хаагчдыг хамруулан “Урлагийн наадам”-ыг 6 төрлөөр 2 үе шаттайгаар энэ оны 04 дүгээр сарын 18-22-ныг өдрүүдэд зохион байгуулж, шалгарсан алба хаагчид хүндэтгэлийн концертод оролцов.

Цагдаагийн алба хаагчдын ур чадвар, тэсвэр хатуужил, авхаалж самбаа, албаны спортыг хөгжүүлэх зорилгоор “Цагдаа-95” цогцолбор тэмцээнийг 7 төрлөөр /хууль, эрх зүй, гадаад хэл, компьютерийн мэдлэг шалгах, буухиа, биеийн хүч, мэх хэрэглэх, гардан тулааны/ Авто бааз, Сургалтын төвийн Нарстай дахь хээрийн сургалтын хэсэг, “Хүч” спорт хороон дээр тус тус зохион байгуулж, төв, орон нутгийн 51 цагдаагийн газар, хэлтсийн 102 алба хаагч хамрагдсан.

Цагдаагийн алба хаагчдын ажиллах орчныг сайжруулах, ажлын байрыг тохижуулах зорилгоор “Ажлын байр-тохилог орчин” сэдэвт хөдөлгөөнийг өрнүүлж, дүгнэн идэвх зүтгэл гарган ажилласан хамт олныг шалгаруулав.

Улаанбаатар хотын цагдаагийн газраас энэ оны 05 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд “Хэсгийн байцаагч-2016”, 04 дүгээр сарын 29-ний өдөр “Хороо-2016” цогцолбор тэмцээнийг алба хаагчдын дунд зохион байгууллаа.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойг тохиолдуулан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ нэр төртэй биелүүлж байгааг төр, засгаас өндрөөр үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал “Сүхбаатарын одон”, мөн Улаанбаатар хотын цагдаагийн газар “Цэргийн гавьяаны улаан тугийн”, Ховд аймаг дахь цагдаагийн газар “Цэргийн гавьяаны”, Замын цагдаагийн алба нийслэлийн “Хангарьд одон”-оор тус тус шагнаж урамшуулсан болно.

*Тав. Дүгнэлт, санал:*

Цагдаагийн байгууллага 2016 онд хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хангалттай биелүүлэн ажиллаа.

Цагдаагийн байгууллагаас 2016 онд нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд анхаарал хандуулж, төр, захиргаа, хууль хяналт, төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй хамтран ажилласны үр дүнд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт 2.1 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт өссөн үзүүлэлттэй байна.

Тухайлбал: Татвар төлөхөөс зайлсхийх хэрэг 82.9, ойн тухай хууль тогтоомж зөрчих 35.1, ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих 36.2, бусдын эд хөрөнгийг булаах 18.5, хүнийг санаатай алах 14.7, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 11.7, танхайрах 8.4, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 7.4, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх 4.8, бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх 3.3, бусдын эд хөрөнгийг хулгайлах 1.1 хувиар тус тус буурсан нь дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүн юм.

Түүнчлэн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гэмт хэргийн зураглал, “Хөршийн хяналт”, “Хяналт”, “Устгал”, “Оюутан-цагдаа”, “Зам тээврийн осол, хэргийн шалтгааныг тогтоох, дүгнэлт гаргах 3D төхөөрөмж” зэрэг арга хэмжээ, төсөл, хөтөлбөр, мөн энэ оны 6, 7, 10 дугаар саруудад зохион байгуулагдсан АСЕМ, УИХ-ын болон Орон нутгийн сонгууль зэрэг томоохон арга хэмжээний бэлтгэл ажлыг сайтар ханган өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажилласнаар 2016 онд буюу эдгээр цаг хугацаанд гэмт хэрэг буурахад нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна.

Хууль эрх зүйн орчинд бий болсон өөрчлөлттэй холбогдон гэмт хэргийн гаралт өөрчлөгдөх төлөв хандлага ажиглагдаж байна. Тухайлбал: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хариуцлага чангарснаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7.4 хувиар буурах шалтгаан болжээ.

Улаанбаатар хотын дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн тоог нэмэгдүүлсэн нь цагдаагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдэд хүрч үйлчлэх боломжийг нэмэгдүүллээ.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дуудлага мэдээллийн давтамж, түүний мөрөөр дүүргүүд дэх цагдаагийн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг эрчимжүүлэх нь гэр бүлийн хүчирхийлэл,

хулгайлах, дээрэмдэх зэрэг тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Цагдаагийн алба хаагчид иргэдтэй зүй бус харьцах, хууль болон хүний эрх, эрх чөлөөг зөрчих, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, сахилга, ёс зүй, ажлын хариуцлага алдах зэрэг зөрчил дутагдалд анхаарлаа чиглүүлж, байгууллагын хүний нөөцийг бэхжүүлэх, анх орох иргэний сонгон шалгаруулалтыг сайжруулах, албаны болон мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтын арга хэлбэр, чанарыг боловсронгуй болгох, албадын уялдаа холбоог зохицуулах явдалд удирдлагын анхаарлыг чиглүүлэх, “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийн төслийг батлуулж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Иймд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй холбогдох хөтөлбөр, төлөвлөгөө, эрх зүйн акт болон “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, шинээр батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, түүнд нийцүүлэн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, байгууллагын ил тод байдал, дотоод хяналтыг сайжруулах бодлого баримталж ажиллах, мөн дэвшилтэд техник, технологийг өргөн ашиглаж шинэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, алба хаагчдын сургалт, сурталчилгааг үр дүнтэй, үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас 2017 онд:

1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх.

2.Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх.

3.Алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах зорилтыг дэвшүүлэв.

Жич:Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаарх мэдээллийг хавсаргав.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР